

6.1.2 Чухал асуудлыг шийдвэрлэх талаарх санал зөвлөмж

- ① Татварын албаны татварын системийн төлөвлөлт, хяналт, анализыг сайжруулах зорилгоор санхүү бүртгэл, мэдээлэл хяналтын системийг бүрдүүлэх
- ② Санхүүгийн болон татварын бүртгэлийн ялгаатай тал, олон улсын бүртгэлийн стандартын дагуу бүртгэл хийх талаарх татвар төлөгчийн ойлголтыг дээшлүүлэх зорилгоор өргөн хүрээний сургалтын системийг нэвтрүүлэх
- ③ Дээрх хоёр зүйлийг хамарсан сургалт семинарыг татварын ажилтнуудад зохион байгуулах
- ④ Татварын бүртгэлд ашиглагдах татварын хуулинд заасан санхүүгийн бүртгэлийн зарчмыг тодорхой болгохын хамт татвар ногдох орлогыг бодитойгоор тооцох аргыг тодорхой зааж өгөх
- ⑤ Татварын тайлантай хамт зардлын тодруулгыг гаргадаг тийм системд шилжих

Цаашид хэрэгжүүлэх ёстой зорилтод дээрх 5 зүйл чухал байр суурь эзэлнэ. Монгол улсад татварын бүртгэлийн системийг нэвтрүүлэх шаардлага зайлшгүй бий. Гэвч татварын хууль боловсронгуй болж, татварын албанд боловсон хүчин хангалттай бүрдсэн цагт л энэ нь боломжтой болох билээ. Одоогийн нөхцөл байдалд түүний урьдчилсан нөхцөл болох санхүүгийн бүртгэл хөтлөх чадварыг дээшлүүлэхийг зорих нь нэн тэргүүний зорилт болох ёстой гэж үзэж байна.

Тухайлбал, Монгол улсын аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар нь Япон улсын аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвартай харьцуулахад татвар ногдох орлогыг тооцох арга нь бага зэрэг ялгаатай байна. Татвар төлөгч нь санхүү бүртгэлийн талаар ерөнхий мэдлэгтэй л байвал цаашдаа татвар хураалтын ажил аяндаа зүгшрээд явчихна. Ялангуяа, татвар төлөгч нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн санхүү бүртгэлийн стандартын дагуу санхүүгийн бүртгэл хөтлөхийн чухлыг ойлгоогүй байгаа явдал их байгаа нь тогтоогдсон. 10 жилийн өмнө Монгол орон нь социалист тогтолцоотой улс байсан бөгөөд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед боловсрол эзэмшиж, олон жилийн турш хуучин бүртгэлийн системээр ажиллаж ирсэн нь зөвхөн татварын албаны ажилтнууд бус юм. Татвар төлөгч болох ард иргэдэд өөрсдөд нь санхүү бүртгэлийн систем огт хэрэггүй байсан юм. Татварын алба нь энэхүү бодит байдлыг харгалзан үзэж, татварын удирдлагыг улам боловсронгуй оновчтой болгохын тулд татвар төлөгчдийн санхүүгийн бүртгэлийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх арга хэмжээ авах шаардлагатай.

Бага зэрэг ялгаатай байж мэдэх ч Монгол улсын болон Япон улсын аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар нь үндсэндээ адилхан нь ойлгомжтой. Японд ч гэсэн дэлхийн 2-р дайны дараа аж ахуйн нэгжийн санхүү бүртгэлийн системийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх шаардлага тавигдаж, түүний нэгдмэл байдлыг хангаж боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай болж ирэхэд аж ахуйн нэгжийн бүртгэлийн зарчим боловсруулж гаргасан юм. Аж ахуйн нэгжийн бүртгэлийн зарчим бий

болгосон талаар удиртгал хэсэгт дурдсан бөгөөд Америк Европтой харьцуулахад үүнийг сайжруулах боломж нөхцөл бололцоо хангалттай байсан. Мөн нөгөөтэйгүүр нэгдмэл бус байсны улмаас үүдсэн аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал болон үйл ажиллагааны үр дүнг зөв тодорхойлоход гарах бодит бэрхшээлээс гарах, эдийн засгийг сэргээхэд нэн тэргүүний зорилт болох гадаадын хөрөнгө оруулалтыг нэвтрүүлэх, аж ахуйн нэгжийг оновчтой зохион байгуулах, татвар ногдуулалтыг тэгш шударга хийх, үнэт цаасны хөрөнгө оруулалтыг либеральчлах, аж үйлдвэрийн санхүүг оновчтой болгох зэргийг зорилгоо болгосон юм. Энэхүү текстийн эхэнд дурдсан ерөнхий зарчим нь үнэн бодит байдал, үнэн зөв бүртгэл, чухал шинж чанар, хөрөнгийн ажил гүйлгээ болон ашиг зарлагын ажил гүйлгээний ялгаа зааг, тодорхой байдал, үргэлжлэх шинж чанар, консерватив шинж болон нэг хэвийн байдал гэсэн найман зарчмаас бүрдэх бөгөөд үүнийг санхүүгийн бүртгэл хийх үед баримтлал болгодог. Энд гарсан үнэн зөв бүртгэлийн зарчимд энэхүү зарчмын дагуу бүх ажил гүйлгээг үнэн зөв бүртгэх ёстой гэж заасан байдаг. Энэхүү зарчимд тавигддаг нэг шаардлага бол бүгдийг хамарсан, баталгаатай, эмх цэгцтэй байх явдал бөгөөд эдгээр зарчмын дагуу санхүүгийн тайлан гаргахын тулд санхүү бүртгэлийг давхар бүртгэлээр хийх ёстой гэж үздэг.

Иймээс Монгол улсад ч гэсэн энэхүү давхар бүртгэлийн системийг нэвтрүүлж, санхүүгийн тайлан, ерөнхий дэвтэр гаргах гэх мэт бүртгэлийг хадгалах арга замын талаар санал гаргахыг хичээх болно. Тухайлбал, татвар төлөгчдөд нягтлан бодох бүртгэлийн талаар өргөн хүрээнд ойлгуулах үүднээс нягтлан бодох бүртгэлийн анхан, дунд, гүнзгийрүүлсэн шатны сурах бичиг гаргах шаардлагатай. Энэ үүднээс түүний нэг загвар болгож нягтлан бодох бүртгэлийн анхан шатны сурах бичгийг бид гаргах болно.

Татвар төлөгчийн ойлголт ухамсар дээшилж, энэхүү бүртгэлийн систем төлөвшөл аажимдаа «Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгчдэд татвар ногдуулах тухай хууль» шиг хуулиудыг эргэн харах шаардлага гарч ирэх бөгөөд үүнтэй уялдан татвар төлөгчийн зүгт гарах тэгш бус байдал ч арилах болов уу. Улмаар татварын тайлангийн чанар ч дээшилж, татварын албаны хяналт шалгалт, статистик зэрэгт үр ашигтайгаар ашиглагдах боломжтой болж ирэх болов уу.

6.1.3 Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны сурах бичгийн ач холбогдол ба түүний зорилго

Энэхүү сурах бичиг нь нягтлан бодолх бүртгэлийн талаар огт мэдлэггүй хүмүүст зориулагдсан болно. Нягтлан бодох бүртгэл гэхээр мэргэжлийн хэцүү ойлголт шиг санагдаж магадгүй юм. Гэхдээ энэ сурах бичгийг уншаад хялбар ойлгогдохоор бичсэн болно.

Нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдлэг нь зөвхөн аж ахуйн нэгж, байгууллагын нягтланд л хэрэг болох зүйл биш юм. Аж ахуйн нэгж, байгууллагын захирал хүн тухайн аж ахуйн нэгжийн санхүүгийн байдлын талаар нарийн мэдлэгтэй байхгүй бол болохгүй бөгөөд энэ нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны цар хүрээнээс хамаарахгүй юм. Мөн

хувиараа худалдаа арилжаа эрхэлдэг хүн ч гэсэн нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдлэг эзэмшсэн байх хэрэгтэй байдаг. Учир нь тухайн худалдаа арилжаа нь үнэхээр ашигтай байгаа эсэх, одоогийн удирдлага менежментийн арга барил цаашид тохирох эсэх зэргийг тайлан бүртгэлээс харж дүгнэж чаддаг байх нь цаашид хэрхэх талаар шийдвэр гаргахад маш их хэрэгтэй.

Нягтлан бодох бүртгэлийг ерөнхийд нь худалдааны байгууллагын бүртгэл, үйлдвэрийн газрын бүртгэл гэж ангилдаг. Энэхүү сурах бичгээс худалдааны байгууллагад хөтлөх нягтлан бодох бүртгэлийн тухай анхан шатны мэдлэгийг олж авах болно. Цаашид энэхүү сурах бичигт тулгуурлан нягтлан бодох бүртгэлийн дунд болон гүнзгийрүүлсэн шатны сурах бичгийг гаргаж, татвар төлөгчдийн мэдлэгийн төвшинг дээшлүүлэхийг зорих хэрэгтэй.

6.2 Татварын нягтлан бодогчийн систем

6.2.1 Монгол улсад татварын нягтлан бодогчийн тогтолцоог нэвтрүүлж буй байдал

Төслийн 1-р үе шатанд татварын нягтлан бодогчийн тогтолцоог нэвтрүүлэх тухай зөвлөж байсан бөгөөд энэ удаа ч гэсэн татварын ажилтны ажиллах урам зоригийг дээшлүүлэх, татвар төлөгчдийн тайлан гаргалтын түвшинг дээшлүүлэхэд ч гэсэн шууд бусаар нөлөөлөх зэрэг ач холбогдолтой гэдгийг тайлбарласан. Өнгөрсөн оны 9 сард Монгол улсын татварын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах үед татварын нягтлан бодогчийн тогтолцоо нэвтрүүлэх тухай хуулинд тусгах тухай зөвлөмж болгосны дагуу Үндэсний татварын ерөнхий газраас боловсруулсан хуулийн төсөлд татварын ерөнхий хуулийн 4-р бүлэгт энэ тогтолцоог хуульчилж өгөхийг санал болгосон. Гэсэн ч УИХ хуулийг хэлэлцэх үед энэ санал батлагдаагүй үлдсэн.

Судалгааны хэсгээс Япон болон АНУ дахь татварын нягтлан бодогч, мэргэшсэн нягтлан бодогчийн өнөөгийн байдлын тухай болон татварын нягтлан бодогчийн тогтолцоог Монгол улсад нэвтрүүлснээр ямар үр дүнд хүрэх тухай бодол саналаа доор танилцуулахын хамтаар татварын нягтлан бодогчийн тогтолцоог нэвтрүүлэхийг дахин санал болгож байна.

6.2.2 Япон болон АНУ дахь мэргэшсэн нягтлан бодогч (CPA) болон татварын мэргэшсэн нягтлан бодогч

[1] Японы байдал

① CPA

Шалгалт өгөх хичээл нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан баланс, өртгийн бүртгэл, хяналт шалгалтын онол, худалдааны хууль (эдгээр нь заавал өгөх шалгалт), менежмент, эдийн засаг, иргэний хууль (эдгээрээс 2-ыг сонгон авч шалгалт өгнө) гэсэн 7 хичээл байна. Эдгээр шалгалтанд тэнцвэл туслах нягтлан бодогч болох бөгөөд практик дадлага хийсний дараа холбоотой хичээлээр эцсийн шалгалт өгдөг. Татварын үйл ажиллагаатай холбоотой эдгээр хичээлийн агуулга нь аж ахуйн нэгж байгууллагын албан татвар тухай хичээл байдаг. Шалгалтад тэнцэгсдийн ихэнх нь их дээд сургуулиудын оюутнууд, их дээд сургууль төгссөн ажил эрхлээгүй хүмүүс байдаг.

Ажлын гол агуулга нь санхүүгийн бичиг баримтын хяналт шалгалт, нотлох үйл ажиллагаа, санхүүгийн баримт бичгийн тулгалт зэрэг нягтлан бодох хяналт шалгалт юм. Японы мэргэшсэн нягтлан бодогчид нь худалдааны хууль, үнэт цаасны арилжааны хуулийн дагуу голчлон хөрөнгийн биржийн арилжаанд оролцож буй компани, оролцоогүй ч гэсэн 500 сая иенээс дээш дүрмийн сантай эсвэл өр төлбөрийн нийт дүн нь 20 тэрбум иенээс давсан хувьцаат компаниуд дээр нягтлан бодох бүртгэлийн хяналт шалгалтыг

явуулдаг. Өөрөөр хэлбэл том аж ахуйн нэгжийг голчлон шалгадаг. Одоогоор Японы өөрийн нягтлан бодох бүртгэлийн стандартад тулгуурлан энэ хяналт шалгалтыг явуулж байгаа бөгөөд глобальчлал өргөжихийн хирээр олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад тохирсон хэлбэрт шилжих шатанд явж байна. Татварын хуулийн зарчмын дагуу санхүүгийн тайлан баланс гаргадаг байсан бол олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг нэвтрүүлснээр нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө татварын хуулийн стандартыг хэрэглэхгүй болох явдал гарч ирнэ. Мэргэшсэн нягтлан бодогч нь компаниийн нягтлан бодох бүртгэл нь нягтлан бодох бүртгэлийн стандарт болон худалдааны хуулинд нийцэж байгаа эсэхийг шалган тогтоож гадны хөрөнгө оруулагчид нарын өмнө түүнийгээ батлах үүрэг хүлээдэг.

Японд одоогоор 12000 орчим мэргэшсэн нягтлан бодогч байдаг (Японы хүн ам 120 сая орчим) .

② Татварын нягтлан бодогч

Шалгалт өгөх хичээл нь нягтлан бодох бүртгэлийн 2 хичээл (Бүртгэлийн онол, санхүүгийн тайлан баланс гаргалт гэсэн 2 хичээл нь заавал шалгалт өгөх хичээл) болон татварын хуулийн талаарх 9 хичээл (ААХБАТХ, ХАОАТХ, Өв залгамжлалын хууль, хэрэглээний татварын хууль г.м) байх бөгөөд татварын нягтлан бодогчийн эрх авахын тулд 5 хичээлийн шалгалтанд тэнцсэн байхаас гадна ААНБОАТХ, ХАОАТХ-ийн аль нэгээр шалгалт өгч тэнцсэн байх ёстой. Үлдсэн хоёр хичээлийн аль нэгийг шалгалт өгөгч өөрөө сонгоно. Татварын нягтлан бодогч болох хүсэлтэй хүмүүс нь татварын нягтлан бодогчийн компанид ажилладаг байх явдал их байдаг тул ажил хийхийн хажуугаар татварын нягтлан бодогчийн эрх авах бололцоог олгохын тулд хичээл тус бүрээр тус тусад нь шалгалт өгч болдог. Өөрөөр хэлбэл, нэгэн зэрэг 5 шалгалтанд тэнцэх шаардлагагүй бөгөөд хэдэн жилийн дотор шалгалтыг дараалан өгч эрх авч болох юм. Шалгалтанд тэнцсэн хүмүүс, шалгалтаас чөлөөлөгдөх хүмүүс (татварын албаны зарим ажилтан)-ээс гадна өмгөөлөгч болон хэрвээ мэргэшсэн нягтлан бодогч өргөдөл гаргавал татварын нягтлан бодогчийн эрх олгодог. Татварын ажилтан тэтгэвэрт гарсны дараа татварын нягтлан бодогчоор бүртгүүлэх явдал татварын нягтлан бодогчийн тогтолцоог нэвтрүүлснээс хойш нилээд их болсон.

Татварын нягтлан бодогчийн ажил нь татвар төлөгчийг татварын албан дээр төлөөлөх, татварын баримт бичиг бүрдүүлэх, татварын зөвлөгөө өгөх зэрэг бөгөөд зарчмын хувьд бие даасан байдалтай байна. Дээрх ажлуудтай холбоотойгоор ...нягтлан бодох бүртгэлийн ажлыг ч гүйцэтгэнэ. Тиймээс мэргэшсэн нягтлан бодогч байлаа гэсэн ч татварын нягтлан бодогчоор бүртгүүлээгүй бол эдгээр ажлыг гүйцэтгэхгүй. Мэргэшсэн нягтлан бодогчийн хувьд ААНБОАТ нь шалгалт өгөх хичээл бөгөөд татварын бусад хуулиудыг бие даан судлахгүй бол татварын нягтлан бодогчийн ажлыг гүйцэтгэхэд хүндрэлтэй.

Японд татварын нягтлан бодогч, мэргэшсэн нягтлан бодогчийн аль аль нь ААНБ, хувь хүнтэй гэрээ байгуулан ажилладаг бөгөөд ажлын хөлсийг гэрээ байгуулсан ААНБ, хувь хүн төлнө. Мэдээж эдгээр зардлыг санхүүгийн болон татварын тайланд зардал болгон тусгахыг хүлээн зөвшөөрдөг.

Мэргэшсэн нягтлан бодогчийн үндсэн ажил нь том компанийн нягтлан бодох бүртгэлийн хяналт шалгалт байдаг бол татварын нягтлан бодогч нь голдуу жижиг дунд үйлдвэр эрхлэгчид болон хувь хүний татварын тайлан тооцоо хийдэг. Жижиг, дунд үйлдвэрт санхүүгийн ажилтан байдаг ч гэсэн тайлан баланс гаргаж чадах хүн цөөн байдаг тул тэдгээрийн ихэнх нь татварын нягтлан бодогчийг гэрээгээр ажиллуулах явдал их байдаг. Тиймээс татвар төлөгчдийн өмнөөс анхан шатны бүртгэл, данс тооцоо хөтөлж, татварын тайлан гаргадаг. Бүртгэл хөтөлж чадахгүй татвар төлөгч ч гэсэн татварын нягтлан бодогчийг ажиллууснаар татварын тайлан гаргахад ямар нэгэн хүндрэл гарахгүй бөгөөд татварын нягтлан бодогч нь татварын албатай тооцоо хийх учраас татвар төлөгч цаг үрэх хэрэггүй болж үндсэн ажилдаа хүчээ төвлөрүүлэх бололцоотой болно.

60000 орчим татварын нягтлан бодогчийн эрхтэй хүн байдаг.

[2] АНУ-ын байдал

① Мэргэшсэн нягтлан бодогч

Шалгалт өгөх хичээл нь санхүүгийн нягтлан бодох бүртгэл тайлан (Financial accounting and reporting), татвар, удирдлагын нягтлан бодох бүртгэл, засгийн газрын нягтлан бодох бүртгэл (Taxation, Management accounting, Governmental accounting), бизнесийн хууль (Business Law), аудит (Auditing) гэсэн 4 төрлийн татвараас өөр төрлийн хичээл байна. Ажлын гол чиглэл нь нягтлан бодох бүртгэлийн аудит хийх явдал.

② Татварын мэргэшсэн нягтлан бодогч (Enrolled Agent=EA)

Шалгалт өгөх хичээл нь ХАОАТ, хувиараа эрхлэх аж ахуй, нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар, өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар, траст (Corporations, Estate and gift tax and trusts) зэрэг татвартай холбоотой хичээл байна.

АНУ-ын татварын нягтлан бодогч (EA=үгчлэн орчуулбал бүртгэлтэй төлөөний этгээд) –ийн ажлыг Японы татварын нягтлан бодогчийн ажилтай харьцуулбал нилээд ялгаатай бөгөөд татварын нягтлан бодогчийн ажлыг гүйцэтгэдэг учраас татварын мэргэжилтэн гэж хэлж болох юм. Америкт Холбооны улсын татварыг хариуцдаг Дотоодын орлогын газар (Internal Revenue Service=IRS)-тай татвар төлөгчийн өмнөөс харьцаж татварын тооцоо хийх эрхтэй хүмүүс нь өмгөөлөгч, мэргэшсэн нягтлан бодогч, татварын нягтлан бодогчийн эрх бүхий этгээдүүд байдаг бөгөөд (зарим нөхцөлд тэтгэврийн (Enrolled Actuaries) ч төлөөлж болдог). Шалгалт өгөх хичээлийн төрлөөс харахад ойлгомжтой бөгөөд мэргэшсэн нягтлан бодогч

ч гэсэн мэргэжлээсээ гадна татварын хуулиудын талаар бие даан суралцсан байх хэрэгтэй.

[3] Японы татварын нягтлан бодогч болон Америкийн татварын нягтлан бодогчийн ялгаа

① Татварын бичиг баримт бүрдүүлэх

Японд татвар төлөгч өөрөө эсвэл татварын нягтлан бодогч гүйцэтгэдэг бол Америкт эрхтэй эсэхээс үл хамааран хэн ч гүйцэтгэж болно.

② Татварын талаарх нэхэмжлэл

Японд бол шүүхэд очих эрхгүй байдаг (Одоо энэ байдлыг өөрчлөх чиглэлээр шинэчлэл хийгдэж байна) ба EA нь АНУ-ын Tax Court Examination-д тэнцэх юм бол Холбооны улсын шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

③ Эрхийн хугацаа

Японд байнгын эрх олгодог бол Америкт тодорхой хугацааны дараа мэргэжлийн сургалтанд хамрагдаж дахин шинээр эрх авдаг.

[4] Японы мэргэшсэн нягтлан бодогч болон татварын нягтлан бодогч

Мэдээллийн нээлттэй тогтолцооны дагуу том аж ахуйн нэгжүүд нь улс, хувьцаа эзэмшигчдэд тайлан балансаа нээлттэй зарлах үүрэгтэй. Эдгээр мэдээллийн бодитой эсэхийг мэргэшсэн нягтлан бодогч хянадаг. Глобалчлал эрчимжиж буй өнөө үед дэлхийн аль ч орны үйлдвэрүүд өрсөлдөөнд үлдэхийн тулд цар хүрээгээ өргөжүүлэхийг зорьж гадаадын үйлдвэрүүдтэй хамтрах, нэгдэх үйл явц өрнөж байна. Иймээс зөвхөн нэг улсын татварын хуулийг судлахаар хязгаарлахгүй олон улсын чиг хандлагын талаас авч үзэх шаардлага гардаг. Хувьцаа эзэмшигчид зэрэг хөрөнгө оруулагчид тухайн аж ахуйн нэгжийн мэдээлэл хэр зэрэг бодитойг анхааралтай ажиглаж байдаг. Мэргэшсэн нягтлан бодогчийн хөндлөнгийн хяналт дүгнэлт нь түүний үндэс болж өгдөг. Түүнээс гадна мэргэшсэн нягтлан бодогч нь удирдлагын зөвлөгөө өгөх үйлчилгээ (Management Adviser Service) үзүүлэх ажил эрхэлдэг. Мөн санхүүгийн судалгаа, төсөл боловсруулах ажил ч гүйцэтгэдэг. Том аж ахуйн нэгжүүд нь татварын тайлангаа өөрсдөө гаргах буюу татварын нягтлан бодогчоор гаргуулдаг. Мэргэшсэн нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогчийн хуулийн дагуу хяналт шалгалт хийдэг аж ахуйн нэгж байгууллагынхаа татварын тайланг гаргаж болохгүй.

Харин жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд гол төлөв дотооддоо үйл ажиллагаа явуулдаг, хувьцаа эзэмшигчид нь гэр бүлийн хүрээгээр хязгаарлагддаг бөгөөд мэдээллийг нийтэд зарлах асуудал хурцаар тавигддаггүй. Мэргэшсэн нягтлан бодогчийн аудит ч шаардлагагүй учраас тайлан балансаа татварын хуулийн стандартын дагуу гаргаж, зөвхөн улсынхаа татварын хуулийг мэдэж байвал болно. Гэсэн хэдий ч жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид татварын хуулинд нарийн мэргэшсэн боловсон хүчнээр дутмаг байх явдал байдаг. Тиймээс нягтлан бодох бүртгэл, татварын асуудлаар мэргэшсэн татварын нягтлан бодогчоос

зөвлөгөө авдаг. Татварын нягтлан бодогч нь хуулийн талаас авч үзвэл татварын алба, татвар төлөгчийн аль алиных нь талд оролгүй төвийг сахисан байр суурьтай байна.

Жижиг дунд үйлдвэрийн тоо том аж ахуйн нэгжээс их байгаагаас харахад ч гэсэн татварын нягтлан бодогчийн тоо их байна.

6.2.3 Татварын нягтлан бодогчийн тогтолцоог нэвтрүүлэх ач холбогдол

Монгол улсад татварын нягтлан бодогчийн тогтолцоог нэвтрүүлэх нь ямар ач холбогдолтой вэ гэдгийг доор дурьдсан зүйлээс харж болно.

Нэгдүгээрт татварын ажилтны ухамсрыг дээшлүүлэх арга хэмжээ болж өгнө. Татварын нягтлан бодогчийн тогтолцоог бий болгох нь татварын ажилтны тэтгэвэрт гарсны дараах эдийн засгийн болон нийгмийн баталгааг хангах асуудалтай холбоотой. Энэ тогтолцоог бий болгосон тохиолдолд татварын ажилтан өөрийн ирээдүйд итгэлтэйгээр өдөр дутмын ажлаа гүйцэтгэнэ. Татварын ажилтны цалин хөлсийг мэдэгдэхүйцээр нэмж чадахгүй байсан ч тэд өөрсдийн цалин хөлсний энэ байдлаа тэсвэрлэн урам зоригтойгоор хүнд хэцүү ажлаа гүйцэтгэх болно. Татварын нягтлан бодогчийн тогтолцоог нэвтрүүлэхийн тулд УТЕГ-аас зохион байгуулдаг шалгалтанд тэнцсэн татварын болон нягтлан бодох бүртгэлийн ажлын туршлагатай этгээдийг татварын нягтлан бодогч болгоно. Татварын албанд ажилласан жилийг харгалзан татварын ажилтныг уг шалгалтаас чөлөөлснөөр тэтгэвэрт гарсны дараа шууд татварын нягтлан бодогч болж болох бололцоотой юм.

Татварын нягтлан бодогчийн энэ тогтолцоо нь татварын ажилтны ирээдүйн нийгмийн баталгаа болоход тус нэмэр болоод зогсохгүй Монгол улсын бусад салбарт ч хэрэглэж болох юм. Үүнийг нэвтрүүлснээр Монгол улсын татвар төлөгчид нягтлан бодох бүртгэл хөтөлж дадаагүй учраас татварын албадын ажилд багагүй хүндрэл гардгийг болиулж чадах юм. Татвар, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн болох татварын нягтлан бодогчид нь татвар төлөгчдийн хүсэлтээр цалин хөлстэйгээр тэдний татварын тайлан, татвар төлөлттэй холбоотой бүх ажлыг хариуцан ажиллах болвол төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд ч үр дүнтэй. Ингэснээр татварын утга учрыг ойлгодоггүй, нягтлан бодох бүртгэл тухай мэдлэггүй татвар төлөгчийн татварын тайлан зохих түвшин хүртэл сайжирч Монгол улсын татварын орлого бүх шатанд өсөх болно гэж бодож байна. Мөн татварын нягтлан бодогч татвар төлөгчийн татвартай холбоотой ажлыг хариуцан хийснээр тэдэнд татвар, нягтлан бодох бүртгэлийн талаар зааж сургах бөгөөд татварын алба татварын нягтлан бодогчдод тавих хяналт удирдлагаараа дамжуулан татвар төлөгчдийг сургалтанд хамруулж чадах болно. Эн бүх үр ашгийг мөнгөнд шилжүүлэх юм бол тооцоолж боломгүй тоо гарна.

Дээр өгүүлсэн шиг татварын нягтлан бодогчийн тогтолцоо нь маш үр ашигтай тогтолцоо учраас УТЕГ энэ тогтолцоог нэн даруй нэвтрүүлэх

тухай шийдвэр гаргаж татварын ажлыг үр дүнтэй зохион байгуулах хэрэгтэй.

Бүлэг 7

7. Хэрэг бүртгэлийн систем

7.1 Хэрэг бүртгэлийн системийн зорилго

Татвар төлөгч хэрэг зөрчил гаргасан нь тодорхой болсон тохиолдолд албадан татварын шалгалт хийнэ. Энэ шалгалтыг хэрэг бүртгэл гэх бөгөөд эцсийн зорилго нь татварын орлогыг хангахад оршино.

Гэхдээ уг албадан шалгалт нь татварын орлогыг хангах, эсвэл эрүүгийн гэмт хэргийг шийтгэх замаар сэрэмжлүүлэх зорилго агуулж байгаа эсэхээс хамааран татварын хэрэг бүртгэлийн арга ялгаатай байна. Эдгээрийн аль нь тухайн улсад нийцэж байгаагаас нь ямар сонголт хийх нь шалтгаална. Япон улс дахь татварын хэрэг бүртгэлийн «нэг удаа шийтгэж мянган удаа сэрэмжлүүлэх» арга барил нь Монгол улсын хувьд ч гэсэн тохиромжтой арга юм. Өөрөөр хэлбэл, хэрэг бүртгэлийн үйл ажиллагаа нь олон нийтэд сурталчилгаа хийх зорилго агуулах ба энэ нь төсвийн орлогыг татварын хэрэг бүртгэлээр шууд хангахад үл чиглэсэн бөгөөд нарийн төлөвлөгөөний дагуу хийгддэггүй хэрэг бүртгэлээс ялгаатай. Энэ санаа нь Америкын татварын хэрэг бүртгэлийн алба шиг их хэмжээний буюу жилд 6000 гаруй хэрэг зөрчил шалгах, хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр сурталчлах хэрэг зөрчилд чиглэсэн сонголт хийхээс өөр юм. Өөрөөр хэлбэл, хэрэг бүртгэл татварын удирдлагын түшиг тулгуур байх ёстой. Үүний шалтгааныг дор дурдав.

- ① Монгол улсад татварын алба үүсч хөгжөөд төдийлөн удаагүй байгаа бөгөөд иргэдийн татварын мэдлэг хомс, татвараас зугтахыг гэмт хэрэг гэж үзэх орчин хараахан бүрэлдэж тогтоогүй
- ② Үүнтэй уялдаад ердийн татварын хяналт шалгалт хийхэд татвар төлөгчийн зөвшөөрөл авах явдал гардаг
- ③ Ийм нөхцөлд албадсан татварын хяналт шалгалт хийвэл татвар төлөгчийн хатуу эсэргүүцэлтэй тулгарах аюултай бөгөөд их цар хүрээг хамарсан татварын хэрэг бүртгэл нь татварын удирдлагын эсрэг татвар төлөгчдийг хандуулахад хүргэнэ.
- ④ Гэхдээ хүчээр ч болов татварын хяналт шалгалт хийж «татвараас чадвал зайлсхий, эс чадвал алдагдалд орно» гэх татвар төлөгчийн сэтгэхүй улам нарийсахад саад хийх хэрэгтэй.
- ⑤ Үүний тулд нарийн зохион байгуулагдсан, мөн хэрэг зөрчил хийсэн нь баримт нотолгоотой объектонд татварын хэрэг бүртгэл хийх тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй.

7.2 Татварын хэрэг бүртгэлийн талаарх ерөнхий ухагдахуун ба түүний зохион байгуулалтын тухай онол

Татварын хэрэг бүртгэлийг ерөнхийд нь «мэдээлэл цуглуулах», «шалгалт хийх» гэсэн хоёр хэсэгт хуваана. Энэ нь хэрэг бүртгэлийн объектыг эхлээд тогтоогоод (мэдээлэл), дараа нь түүнд газар дээр нь шалгалт хийхийг хэлнэ. Эдгээр ажлууд нь харилцан хамааралтай бөгөөд аль аль нь чухал ач холбогдолтой. Иймд тухайн ажил үүргийн хувиараас нь хамааран хэрэг бүртгэлийн хэлтэс дотор бие даасан тасгуудын зохион байгуулалттай байх

нь үр дүнтэй байдаг. Дор эдгээр тасгуудийн ажил үүрэгт онцлон анхаарах асуудлын талаар тэмдэглэв.

[1] Мэдээлэл цуглуулах хэсэг

Хэрэг бүртгэлийн объект болох татвар төлөгчийг нууц тандалт хийж сонгох үүрэг хүлээх ба үүний тулд мэдээлэлийн эх үүсвэрийг олж нээх асуудал гардаг. Тухайлбал, дор дурдсан мэдээлэлийн эх үүсвэрийг харгалзаж үзэх хэрэгтэй. Мэдээлэлийн ажил далд хийгдэх тул олон талаас нь нарийн тооцоолох хэрэгтэй байдаг.

Мэдээллийн зарим хэсгийг ердийн хяналт шалгалтын үеэр олж авах ба хэрэг бүртгэлийн хэсгээс нэхэмжилж шаардаагүй тохиолдолд ч гэсэн бусад татварын албадаас мэдээлэл автоматаар орж ирэх тогтолцоо бүрдүүлэх хэрэгтэй. Гэхдээ мэдээлэлийн нууцлалтай холбоотой асуудал гарч болох хэдий ч үүнээс үл хамааран татварын албадтай идэвх санаачлагтай хамтран ажиллахгүй бол тэр болгон мэдээлэлээр хангагдах боломжгүй юм. Татварын хэлтэс бүр тус тусын хүлээсэн үүрэгт ажилдаа анхаарч бусад хэлтсийн хэрэгт хутгалдахгүй байхыг боддог. Иймд алсыг харсан бодлого хэрэгжүүлэхгүй бол мэдээлэл амархан орж ирэхгүй. (мэдээлэл солилцох систем нэвтрүүлж, өндөр албан тушаалтай хүнээр удирдуулан мэдээлэл солилцох тогтолцоог бэхжүүлэх, мэдээлэл солилцох татварын хэлтэс тасагт зааварчилгаа өгөх гэх мэт)

Үүний дараа гуравдагч этгээдээс авах мэдээлэл орно. Уг мэдээлэл дотор аж ахуйн нэгжийн харилцагч байгууллагаас олж авсан дотоод мэдээлэл зэрэг шууд үр дүн үзүүлэх зүйл цөөнгүй байдаг. Ийм мэдээлэлийг цуглуулахын тулд мэдээж зардал гарна. Мэдээлэлийн «урамшуулалын систем»-ийг иргэд ойлгож ухамсарласан нөхцөлд үр дүнтэй байдаг. Мөн ердийн мэдээлэлийг сайтар шүүвэл ашиглаж болох баримт болдог ба мэдээлэл шинэлэг байх нь чухал бөгөөд он удаан жил хуримтлуулсанаар үр дүнгээ харуулах мэдээлэл ч байдаг.

[2] Хэрэгжүүлэх хэсэг

Уг хэсэг нь хэрэг зөрчилтэй татвар төлөгчийг шалгах хэлтэс юм. Татварын хэрэг бүртгэлийн зорилготой уялдан эрүүгийн хэргийг шүүх байгууллагад шилжүүлэх үүрэг хүлээх ба үүний эцсийн үр дүнд сэжигтэнд хэрэг үүсгэж түүний буруутай эсэх талаар шүүхээр шийдвэрлүүлэхгүй бол хэрэг бүртгэлийн ажил өөрийн зорилгоо биелүүлж чадсангүй гэж үзнэ.

Иймд шүүхэд шилжүүлсэнээс хойших хэрэг бүртгэлийн ажлыг саадгүй явуулахын тулд татварын хяналт шалгалтын явцад прокурорын зааврыг авч өдөр тутмын шалгалтанд ашиглах харилцан итгэлцсэн холбоо тогтоох хэрэгтэй.

Прокурорын байгууллагтай тогтоосон энэхүү хамтын ажиллагаа нь зөвхөн хяналт шалгалтаар дамжин хэрэгждэг бол хангалтгүй юм. Татварын гэмт хэрэг бусад эрүүгийн хэргээс ялгагдах олон элемент агуулдаг тул

татвараас зайлсхийгч этгээд болон ийм хэрэг гаргахад бэлэн бусад татвар төлөгчид зөөлөн хандах хяналт шалгалтын хэлтсийн татвараас зайлсхийх хэрэг зөрчлийг шалгах ажлыг нэг талаар хянаж нотолгоо баримт гаргаж авах үүднээс тактик боловсруулж татвараас зайлсхийх нь гэмт хэрэг гэж ухамсаруулахын тулд их идэвх санаачлага гаргах болдог.

Энэ утгаар мөрдөн шалгаад зогсохгүй хууль хяналтын байгууллагт татварын мэдлэгтэй хүнийг ажиллуулах, улмаар эрдэм шинжилгээний байгууллага (татварын хууль тогтоомжийн судлагаа явуулах), зарим тохиолдолд хэвлэл мэдээлэлийн байгууллагуудтай хамтран ажиллах (боломжтой гэж үзсэн хүрээний мэдээлэлийг гадагш задруулах явдал ч гэсэн нэг арга болно) талаар судалж үзэх хэрэгтэй.

[3] Хэрэг бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалт болон онолын асуудлууд

1) Тусгай мэргэшсэн зохион байгуулалттай байх

Хэрэг бүртгэлийн хэсэг татвараас зайлсхийх этгээдийг шалгах, шүүхэд шилжүүлэх ажлыг дагнан эрхэлдэг байх нь тохиромжтой. Тухайлбал, монголын өнөөгийн хэрэг бүртгэлийн хэлтсийг аваад үзэхэд дотоод хяналт буюу татварын албадын доторх зөрчил шалгах байцаагч нарын тухайд бусад хэлтэс тасгаас туслалцаа авах хэрэгцээ их гардаг ба хэрэг бүртгэлийн мэдээлэлийг цуглуулах ажлыг давхар хийлгэх боломжгүй юм. Иймд дотоод хяналтын ажлыг татварын хэрэг эрхлэх зэрэг газарт өөр зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх нь тохиромжтой. Мөн татвар хураалтын ажил нь татвар ногдуулалтын ажлаас өөр харгалзаж үзэх зүйл олон байдаг тул урьдаас энэ ажлыг хариуцаж ирсэн хэсэгт даатгах нь үр дүнтэй юм.

2) Хэрэг бүртгэлийн байцаагч өндөр ур чадвартай байх

Хэрэг бүртгэлийн ажлын онцлогыг харгалзан тухайн ажилд өндөр мэдлэгтэй, тухайлбал мэдээлэлийн хэсэгт «сэтгэх чадвар», хэрэгжүүлэх хэсэгт «ухуулах чадвар»-ыг голчлон хяналт шалгалтын арга барил сайтай, тэсвэр тэвчээртэй хүнийг сонгоно. Мөн тухайн байцаагчийн ур чадварын талаар тухайн хэлтсийн байцаагч нарт танилцуулж урамшуулах хэрэгтэй.

3) Боловсон хүчнийг бэлтгэх

Хэрэг бүртгэлийн байцаагчаар олон ээдрээтэй хяналт шалгалт хийж байсан туршлагатай хүнийг сонгох хэрэгтэй ба эрүүгийн хэргийн процедурын талаар анхан шатны мэдлэг эзэмшсэн байх нь хэрэг бүртгэлийн ажилд тустай. Мөн шүүх прокурорын байгууллагтай боловсон хүчин харилцан солилцох замаар хэрэг бүртгэлийг удирдан хийх байцаагч нарыг бэлтгэнэ. (эрүүгийн хэргийн процедурыг богино хугацаанд эзэмшиж болох боловч татварын хяналт шалгалт хийхэд

олон жилийн туршлага хэрэгтэй. Иймд татварын байцаагч нарт эрүүгийн хэргийн процедурын талаар дадлага хийлгэх нь чухал юм.) Үүний дараа эдгээр байцаагч нараар удирдуулсан групп байгуулж хэрэг бүртгэлийн ажлыг өндөр зохион байгуулалттай хэрэгжүүлэх боломжтой болно. Гэхдээ ийнхүү бэлтгэсэн байцаагч хэсэг хугацаанд мэргэшсэн хэрэг бүртгэгчээр ажиллах хэрэгтэй. Мөн хэрэг бүртгэлийн хэлтсийг мэдээлэлээр хангах хэлтэс хоорондын хамтын ажиллагаа нь бусад байцаагийн хувьд ажил үүргийнх нь нэгэн хэсэг байхуйцаар арга хэмжээ (тухайлбал, мэдээлэл дамжуулах систем бий болгож мэдээлэл дамжуулсан хүнийг урамшуулах) авах нь хэрэг бүртгэлийн ажлын талаарх ойлголтыг дээшлүүлж хэрэг бүртгэлийн байцаагчаар ажиллах сонирхол бий болгох, өөрөөр хэлбэл хэрэг бүртгэлийн ажлын хүрээг тэлэхэд үр дүнтэй.

4) Хэрэг бүртгэлийн объектыг сонгох хэмжүүр боловсруулах

Хэрэг бүртгэлийн объектыг сонгох хэмжүүр боловсруулах нь хэрэг бүртгэлийн ажлыг оновчтой үр ашигтай хэрэгжүүлэхэд тустай. Татварын удирдлагын хувьд ч гэсэн хэрэг бүртгэлийн ажлыг зохих төлөвлөгөөний дагуу бодлогтойгоор хэрэгжүүлдэг байх хэрэгтэй. Энэ нь хэрэг бүртгэлийн ажилд хандах иргэдийн итгэлийг бий болгох алхам болох бөгөөд үүний тулд татвараас зайлсхийх арга хэлбэр, хэрэг бүртгэлийн объектийг сонгох, эрүүгийн хэргийн мөрдөн байцаалт хийх шаардлагтай гэмт хэргийн үзүүлэлтийг боловсруулах хэрэгтэй.

Бүлэг 8

8. Татварын маргаан

8.1 Татварын маргааныг шийдвэрлэж байгаа өнөөгийн байдал болон тулгарч байгаа бэрхшээлтэй асуудал

Монголд татварын байгууллага татвар ногдуулалт, татварын хяналт шалгалт болон татвар хураалтын үйл ажиллагааны талаар татвар төлөгч шүүхэд гомдол мэдүүлсэн тохиолдолд ялагдах явдал олон байдаг. Аливаа татварын маргааныг шийдвэрлэх гол үүд хаалга болох татварын хууль тогтоомжинд заасан эрх үүрэг, хуулийн заалтыг зөрчсөн хэрнээ татвар төлөгч шүүхэд гомдол мэдүүлж татварын алба ялагддаг тохиолдолд байдаг. Энэ нь дараах хэд хэдэн учир шалтгаантай холбоотой.

Нэгдүгээрт, энэ нь татварын албаны байцаагч нарын эрх хязгаарлагдмал байдагтай холбоотой. Тухайлбал, хяналт шалгалтаар татвараас зайлсхийсэн татвар төлөгчийг илрүүлэх, татвараас гадуурх эд хөрөнгийг олж тогтоосон ч гэсэн банкны харилцах дансны үлдэгдлээс бусдыг татвар төлөгч хувь хүн эсвэл аж ахуйн нэгж, байгууллагаас зөвшөөрөл аваагүй л бол хүчээр хураан авч чаддаггүй, түүнчлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг хэрнээ орлогын тайлан гаргадаггүй аж ахуйн нэгж, байгууллагад зөвхөн жишиг татвар ногдуулах л эрх хуулиар олгогдсон байдаг.

Хоёрдугаарт, татварын маргаан таслах шүүгч нь татварын талаар мэдлэг хомс, татвар төлөгчөөс хээл хахуул авдаг, шүүх байгууллагад өөрт нь ардчилсан үзэл дутмаг байдгаас татвар төлөгчийн талд ашигтай шийдвэр гаргадаг гэж үзэж болно.

Гуравдугаарт, татварын хяналт шалгалтын түвшин сул тул шүүхэд татвар төлөгчийн талын тайлбарыг няцаах, заргаа авч чадахуйц, татвар ногдуулалтыг бүрэн гүйцэд нотлох баримт дутмаг байдаг зэрэг шалтгааныг дурдаж болно.

Энэ мэтчилэн, Монгол улсын татварын байцаагч улс болон орон нутгийн төсвийн орлогыг хариуцагч болохын хувьд эдлэх ёстой хуулиар олгогдсон эрх нь өнөөгийн байдлаар нэлээн хязгаарлагдмал бөгөөд хэрэгжүүлэх механизм бараг бүрдээгүй, татварын маргааныг шийдвэрлэх шүүх, хуулийн байгууллагын үйл ажиллагаа учир дутагдалтай, заргыг өөрийн талд ашигтайгаар эргүүлэх нотлох чадвар дутмаг зэрэг асуудлыг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Хууль зүйн хэлтсийг шинэчлэх бодлогын талаар дор дурдав.

8.2 Татварын маргаан шийдвэрлэх арга замыг боловсронгуй болгох тухай санал

[1] Татварын байгууллага, татварын байцаагчийн хууль ёсны эрхийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ холбогдох хууль тогтоомжийн бүрхэг зүйл ангийг боловсронгуй болгох хэрэгтэй.

Ялангуяа, Татварын Ерөнхий Хуулийн 24-р зүйл, Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуулийн 17, 36-р зүйлд заасан эрх үүргийг өргөжүүлэхийн зэрэгцээ «бодит татвар ногдуулалт болон хураалтын зарчим»-ыг ТЕХ-д шинээр оруулах хэрэгтэй.

Дээр дурдсан зүйл ангийн тухайд нэгдүгээр хэсэгт (татварын системд тулгарч буй бэрхшээлтэй асуудал болон шинэчлэх бодлого) дурдсаны дагуу ихэнх хэсэгт нь өөрчлөлт оруулсан тохиолдолд татварын маргаан шийдвэрлэх арга замыг боловсронгуй болгох тодорхой жишээ болгох үүднээс зүйл анги тус бүрээр нарийвчилсан тайлбар гаргах хэрэгтэй.

[2] Батламж нотолгоо гаргах чадварыг нэмэгдүүлэх хэрэгтэй

Татвар төлөгчийг шүүхэд мэдүүлэхээс өмнө эрүүгийн болон иргэний байцаан шийтгэх хуулийн дагуу бүрэн гүйцэд нотлогоо болох баримт материалыг цуглуулах хэрэгтэй байдаг. Гэтэл татварын байцаагч хяналт шалгалт хийх тохиолдолд татвар төлөгчийн данс бүртгэл, анхан шатны бүртгэл зэрэг нотлогоо баримт байхгүй, эсвэл байсан ч гэсэн бүрэн гүйцэд хөтлөгдөөгүй, хагас дутуу зэрэг шалтгаанаар татвар ногдох орлогыг бодитоор тооцох боломжгүй байдаг тул хяналт шалгалтын үр дүнг одоо хэрэглэж байгаа хэрхэн тооцоо хийх аргагүй нь нарийн боловсрогдоогүй жишиг татварын аргаар голчлон шийдвэрлэдэг. Үүний улмаас нотлох баримт хомсдож, шүүхэд ялагдал хүлээхэд хүрдэг.

Өөрөөр хэлбэл, татвар төлөгчийн татварын тайлан үнэн зөв эсэхийг тогтоох байнгийн хөдөлшгүй нотолгоо баримтгүйн улмаас хяналт шалгалтын байцаагчийн ажилд хүндрэл үүсч жишгээр татвар ногдуулахаас өөр аргагүй байдалд хүрдэг. Гэхдээ хяналт шалгалтын байцаагчийн ур чадвар хангалтгүй байдаг зэрэг нь ажлын үзүүлэлт муу байгаагийн бас нэгэн шалтгаан юм. Татвар төлөгчийн үйл ажиллагааг батлах баримт байсаар байтал татварын байцаагч бодит орлогыг тогтоож чадахгүй байх явдал ч олон байдаг. Иймд татварын байцаагч зайлшгүй бодит баримтан дээр тулгуурлаж түүнийг лавшруулан судлах замаар хяналт шалгалт хийж татвар төлөгч хуурмаг тайлан гаргасан, татвар ногдох орлогоо багасгаж мэдэгдсэн зэрэг зөрчлийг заавал холбогдох нотлох баримтаар батлаж байх ёстой. Аргагүй шалтгаанаар жишиг татвар ногдуулахдаа маргаан үүссэн тохиолдолд ялагдахгүй байхуйц аргыг сонгож татвар ногдуулах хэрэгтэй бөгөөд ийм жишиг татварын аргазүйг ҮТЭГ яаралтай судалж үзэж, нэвтрүүлэх хэрэгтэй. Энэ талаар 2-р бүлгийн «жишиг татвар»-д санал зөвлөмж болгосон болно.

Түүнчлэн «албан ёсны квитанцийн систем»-ийг нэвтрүүлсэн тохиолдолд бэлэн нотлох баримттай болохоос гадна уг баримтын нотлох чадвар өндөр тул албан ёсны квитанцийг баталгаа баримт болгон ашигласнаар татвар төлөгч шүүхэд зарга мэдүүлсэн тохиолдолд татварын алба ялагдах явдал бараг алга болно.

- [3] Татварын маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэх хэрэгтэй.

Татварын маргаан таслах зөвлөл аливаа маргааныг шийдвэрлэхдээ дараагийн шатанд татвар төлөгч шүүхэд гомдол мэдүүлж болзошгүй гэдэг үүднээс нарийн судлах хэрэгтэй. Ийнхүү маргаан таслах зөвлөлийн шийдвэр гарсаны дараа шүүхэд мэдүүлэхээр заасан тохиолдолд уг зөвлөлийн байнгийн гишүүнд Хууль зүй, дотоод хэргийн яам болон шүүх хуулийн байгууллагын ажилтанг оруулах хэрэгтэй. Эдгээр зөвлөлийн байнгийн гишүүд нь эхний үе шатнаас нь эхлээд татварын маргааныг судлах тул дараа нь шүүхэд зарга мэдүүлсэн тохиолдолд татварын алба заргаа алдах явдал багасах болно. Энэ мэтчилэн татварын маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэхийн тулд хууль зүйн үүднээс нь нарийн судлах хэрэгтэй.

- [4] Татварын алба шүүх хуулийн байгууллагатай хамтарсан (Хууль зүй, дотоод хэргийн яам, Дээд шүүх) байнгийн ажиллагаатай зөвлөл яаралтай байгуулах хэрэгтэй.

Өмнө дурдсанчлан татварын маргаан гарахад татварын алба ялагддаг шалтгаан олон янз байна. Үүний гол шалтгаан нь татварын алба болон шүүх хуулийн байгууллагын хооронд татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуулийн заалт, тайлбар, ойлголт зөрдөгтэй холбоотой тул байнгийн ажиллагаатай зөвлөл байгуулах замаар нэгдсэн ойлголт, тайлбар гаргах хэрэгтэй. Хууль шүүхийн байгууллага уг зөвлөлийг байгуулахад идэвх санаачлагтай оролцож зөвшөөрөөгүй тохиолдолд татварын шүүх байгуулах асуудлыг Засгийн Газар даруй хэлэлцэх хэрэгтэй.

Бүлэг 9

9. Авилгалаас урьдчилан сэргийлэх систем

9.1 Татварын албаны ажилтны авилгалтай холбоотой асуудлууд

Өнөөдөр Монгол улсад татварын байцаагч хээл хахууль авах зэргээр албан тушаалаа урвуулан ашиглах явдал газар авсаар байгааг хүн бүхэн мэдэж байгаа билээ. Ялангуяа, хяналт шалгалтын байцаагч ийм төрлийн хэрэг зөрчил олонтаа гаргадаг.

Авилгал авах хамгийн түгээмэл хэлбэр нь шан харамж авч ногдуулах татварын хэмжээг багасгах явдал юм. Ийнхүү шан харамж авдаг гол шалтгаан нь татварын байцаагчийн ёс суртахууны асуудлаас илүүтэйгээр тэдний цалин хөлс бага байдагтай холбоотой. Цалин хөлс багатай байцаагч татвар төлөгч хэмээх мөнгөтэй хүнтэй шууд харилцах, түүнээс татвар гэх мөнгө хурааж авах ажил хариуцаж байгаа тохиолдолд өөрөө санаачлага гаргаад зогсохгүй татвар төлөгчийн зүгээс идэвхийлэн урхидах явдал олон байдаг. Энэ нөхцөлд байцаагчийн ёс суртахууныг дээшлүүлэх гэж хичнээн хичээгээд ч авилгалаас урьдчилан сэргийлэх, таслан зогсооход нэлээн бэрхшээлтэй байдаг. Иймд байцаагчийн ёс суртахууныг дээшлүүлэхийн зэрэгцээ тэдний цалин хөлсийг нэмэгдүүлэх асуудлыг нэгэн зэрэг авч үзэх хэрэгтэй.

9.2 Авилгалаас урьдчилан сэргийлэх бодлогыг боловсронгуй болгох нь

[1] Татварын байцаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар

Татварын байцаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй бол авилгал газар авсаар байх болно. Иймд төрийн албан хаагчдийн цалингийн нормативаар тогтоосон татварын байцаагчийн цалинг ямар аргаар нэмэгдүүлэх вэ гэдэг асуудал чухлаар тавигдаж байна. Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд мэдээж хууль зүйд нийцтэй нотолгоо хэрэгтэй.

Тодорхой жишээ дурдвал, ойрын хугацаанд ТЭХ-ийн 27-р зүйлийг өөрчилж «Үндэсний Татварын Ерөнхий Газар татварын хяналт шалгалтаар хураан авсан торгууль, нөхөн татварын тодорхой хэсгийг өөрийн төсөвт оруулж захиран зарцуулна» гэсэн заалт нэмж оруулах хэрэгтэй. Энэхүү заалтыг нэмсэнээр бүх шатны татварын албад ажил үүргээ хэрэгжүүлэхдээ олж хураасан торгууль, нөхөн татварын тодорхой хэсгийг ердийн төсвөөс тусад нь цуглуулан хуримтлалыг бий болгож үүнийгээ байцаагчийн цалинг нэмэгдүүлэх эх үүсвэр болгох хэрэгтэй. Ингэснээр татварын байцаагч одоогийнхоос илүүтэйгээр идэвхтэй ажиллахын зэрэгцээ авилгалд өртөх явдал багасах болно. Татварын байцаагчийн авилгалаас болоод улсын төсөвт орох татвар, алданги багасах тул ойрын хугацаанд уг системийг нэвтрүүлэх шаардлагатай ба энэ нь Монгол улсын Засгийн Газрын хувьд төдийлөн хүндрэлтэй асуудал биш юм. Энэ системийг нэвтрүүлсэн тохиолдолд ҮТЕГ цуглуулсан төсвөө ил тод, шударгаарь тогтсон журмаар

байцаагч нарт хувиарлах болно. Ийнхүү хуримтлал нь цалингийн нэмэгдэлд хувиарлагдаж эцсийн дүндээ бүх татварын албан хаагчдад хувиарлагдахуйц зүй зохистой системийг бүрдүүлэх хэрэгтэй. Мөн торгууль, нөхөн татварыг их хэмжээгээр нэмэгдүүлсэн байцаагчид тусгай шагналт цалин олгох зэрэг замаар тухайн байцаагчийн ажлын үр бүтээмжээс хамааран хариу арга хэмжээ авах хэрэгтэй. Гэхдээ олж цуглуулсан торгууль, нөхөн татварын тодорхой хувийг цалин хөлс болгон олгож болохгүй.

[2] Авилгалтай холбоотой мэдээлэл шалгах ажилтан томилон ажиллуулах талаар

Авилгалаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох бодлогын хүрээнд тусгайлан авилгалтай холбоотой мэдээлэл шалгах ажилтанг томилон ажиллуулах нь чухал ач холбогдолтой. Энэхүү ажилтан нь ҮТЕГ-ын даргын шууд удирдлаган дор татварын байцаагчийн авилгалын үйлдлийг илрүүлэх, авилгалтай холбоотой мэдээлэл судлах үүрэг гүйцэтгэнэ. Бусад байцаагч нарт уг албан тушаалтаны талаар мэдэгдэлгүйгээр төрөл бүрийн мэдээлэл цуглуулах ажлыг далдуур идэвхтэй өрнүүлж байцаагч нарт авилгалаас урьдчилан сэргийлэх талаар зааж сурган хээл хахуулийн болон авилгалын шинжтэй хэрэг зөрчлийг ҮТЕГ-ын дотоодод илрүүлэх үүрэг хүлээнэ. Мөн татварын байцаагчийн авилгалтай холбоотой гадны эх үүсвэр бүхий мэдээллийг цуглуулах (мэдээлэл ирэх тогтолцоог бий болгох хэрэгтэй), хээл хахууль, шан харамж олгох магадлалтай татвар төлөгчдөд газар дээр нь хараа хяналт тавих, татварын байцаагчийн биеийн байцаалтыг судлах зэргээр авилгал гарах нөхцөл байдлыг олж тогтоох хэрэгтэй. Энэхүү авилгалтай холбоотой мэдээлэл шалгах систем нь Монгол улсад хараахан нэвтрээгүй байгаа бөгөөд татварын байцаагч холбогдох дүрэм журам мөрддөг болгохын тулд яаралтай нэвтрүүлж хэрэгжүүлэх хэрэгтэй.

[3] Татварын байцаагчдийг тогтоосон хугацаанд сэлгэн ажиллуулах системийг боловсронгуй болгох, татварын мэргэшсэн нягтлан бодогчийн системийг нэвтрүүлэх

Аливаа албан тушаалтан өөрийн хариуцах ажил болон удирдлагадаа дассанаас болж авилгал үүсдэг гэж үздэг. Иймд ҮТЕГ-ын нэгдсэн зааврын дагуу татварын байцаагчийн хувиарлагдах хэлтэс, тасаг болон хариуцах ажил үүргийн хувиар зэргийг нь жилд нэг удаа сэлгэж солих хэрэгтэй байдаг. Учир нь албан тушаалаа урвуулан ашиглаж байгаа байцаагчийн харъяалагдах хэлтэс, тасаг болон ажил үүрэг өөрчлөгдсөнөөр тухайн байцаагчийг хариуцах удирдлага ч гэсэн өөрчлөгдөх тул олон удирдлага дор ажиллахад албан тушаалаа урвуулан ашиглах боломжгүй болдог. Мөн энэ тохиолдолд татварын байцаагчийн ажил үүргийн тодорхойлолтыг системчлэх замаар өмнөх хэлтэс, тасгийн даргаас дараах удирдлагад нь тухайн байцаагчийн хувийн хэрэг шилжиж хадгалагдах тул биеийн байцаалтаас нь авилгалаас урьчилан сэргийлэх, таслан зогсоох боломжтой болно.

Түүнчлэн, татварын байцаагчийн ёс суртахууныг дээшлүүлэх замаар албан тушаалын байдал, боломжоо урвуулан ашиглах явдлыг таслан зогсоохын тулд ажилласан жилийн нэмэгдэл, шилдэг байцаагчид олгох шагнал урамшууллын системийг боловсронгуй болгох хэрэгтэй. Ажилласан жилийн нэмэгдлийг заасан хугацаанд ажилласан хэн ч хүртэх боломжтой юм. Харин шилдэг байцаагчид олгох шагналыг олгохдоо тогтоосон шалгуурын дагуу сонгож тухайн байцаагчийн ур чадварыг хамт олон, байгууллага дотроо өргөн сурталчилж урамшуулах хэрэгтэй.

Татварын байцаагчийн авилгалаас урьдчилан сэргийлэхэд татварын мэргэшсэн нягтлан бодогчийн систем чухал ач холбогдолтой. Татварын байцаагч тэтгэвэрт гарсаны дараа тухайн ажилласан жил зэргээс хамааран татварын мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг авч болохуйц системийг нэвтрүүлсэн тохиолдолд татварын байцаагч хээл хахууль авахаас илүүтэйгээр мөнгө санхүүгийн хувьд хүндрэлтэй байсан ч ажиллах жилээ гүйцээхийг чухалчлах болно.

Бүлэг 10

10. Татвар төлөлтийн орчныг бүрдүүлэх нь

Татварын боловсрол ба татварын зар сурталчилгааны бодлогын талаар тус судалгааны хэсгийн зүгээс судалгааны эхний шатанд санал дэвшүүлж байсан бөгөөд энд тэр талаар нэмж өгүүлэх болно.

10.1 Татварын боловсрол

- (1) Тус судалгааны хэсэг нь судалгааны эхний шатанд өнөөгийн татварын боловсрол нь зөвхөн насанд хүрсэн татвар төлөгчдөд татварын суртчилгааны хэлбэрээр явагдаж байсан тул татвар төлөх үүргийн талаарх ухамсрыг зөвхөн татвар төлөгчдийн хүрээнд бус нийт ард иргэдэд төлөвшүүлэх ёстой талаар санал дэвшүүлсэн бөгөөд Монгол улсын алс ирээдүйд чиглэсэн татварын сургалтын төлөвлөгөө боловсруулж, бага, дунд сургууль болон их дээд сургуульд татварын боловсрол олгох сургалтыг тасралтгүй оруулах нь зүйтэй бөгөөд татвар төлөгчийн эрх болон үүргийн талаар ирээдүйн татвар төлөгч болох хүүхэд залууст сурах бичгээр дамжуулан төрийн хэмжээнд энэхүү боловсролыг олгох шаардлагатай тухай санал дэвшүүлсэн билээ.

Татварын боловсрол гэдгээр зөвхөн төлөх татварын хэмжээг тооцох бүртгэл тооцооны аргыг заах төдий бус энэ нь ардчилсан нийгмийг хөгжүүлэхэд татвар ямар үүрэг роль гүйцэтгэх зэрэг олон зүйлийг хамрах юм. Иймээс татварын боловсролыг төр нийгмийн тогтолцооны сургалтын нэг хэсэг болгон авч үзэх хэрэгтэйг энд хэлэх байна.

Тус судалгааны хэсэг нь судалгааны 2 дахь шатанд одоогийн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдад энэ талаар тайлбарлаж танилцуулсан бөгөөд боловсролын сайдын зүгээс бага, дунд сургуулийн боловсролд татварын боловсролыг нэвтрүүлэх талаар, мөн Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны бага, дунд боловсрол хариуцсан хэлтсийн дарга болон ҮТЕГ-ын сургалт мэдээллийн төвтэй энэ талаар ярилцана гэж нааштай хандсан билээ. Гэхдээ энэхүү боловсролын асуудлыг хэрэгжүүлж эхлэхэд юуны түрүүнд доорхи бэрхшээлтэй асуудлууд гарах тул Монгол улсын Засгийн газраас энэ талаар шийдвэртэй арга хэмжээ авууштай юм.

Эхний асуудал бол татварын боловсролыг хэрэгжүүлж эхлэхэд түүнийг заах бэлтгэгдсэн багш нар байхгүй тул тэднийг бэлтгэх талаар арга хэмжээ авах хэрэгтэй бөгөөд сургуулийн багш нарт татварын боловсрол олгох явдал нь өнөөгийн Монголын ҮТЕГ-ын нөөц бололцооноос харвал бүрэн бололцоотой.

Хоёрдахь асуудал нь сурагчдын үзэх сурах бичгийг зохиох болон түүнд шаардагдах зардлын асуудал юм. Сурах бичгийг зохиох тал дээр ҮТЕГ, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай тохирсны үндсэн дээр ямар ч асуудалгүйгээр явуулах боломжтой боловч түүнд шаардагдах зардлыг ҮТЕГ, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны зүгээс өнөөгийн нөхцөлд гаргаж чадна гэж үзэх боломжгүй тул Монгол улсын Засгийн

газраас зохих арга хэмжээ авахыг хүсч байна. Ямар ч байлаа гэсэн ҮТЕГ, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам энэ талаар нэн даруй хэлэлцэх хэрэгтэй.

- (2) Татварын холбогдолтой төрөл бүрийн судалгааны төвшинг дээшлүүлэх талаарх арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Энэ нь өнөөгийн татварын системийг боловсронгуй болгоход шууд хамааралтай арга хэмжээ болж өгөхөөс гадна дээрх арга хэмжээнд зайлшгүй шаардлагатай, зүйрлэж хэлбэл татварын боловсролын төлөө хийх дэд бүтцийн шинжтэй хөрөнгө оруулалт юм.

Тухайлбал, татварын үндсэн судалгааг эрчимжүүлэхийн тулд гол гол их сургуулиудын хууль, санхүү, нягтлан бодох бүртгэлийн ангид татварын судалгааны хичээлийг оруулж, судлаач нарыг бэлтгэхэд анхаарах хэрэгтэй. Судалгааг олон улсын байр сууринаас хийх хүмүүсийг урамшуулж ажиллах нь Монгол улсын татварын системийн бодит судалгаа, мөн олон улсын байр сууринаас харсан татварын системийн судалгаанд түлхэц өгөх тул илүү их үр дүн өгнө гэж бодож байна.

- (3) Засгийн газрын аппаратанд татварын судалгааг хөгжүүлэх ажлыг хариуцах хэлтэс (Зөвлөлийн эрх мэдэл бүхий байгууллага байсан нь илүү тохиромжтой. Тодорхой нэг судалгаа хийх тохиолдолд төслийн баг бүхий уян хатан тийм байгууллага ч байж болох юм.) байгуулахыг санал болгож байна. Ийм байгууллага буй болгох нь холбогдох төрийн байгууллагын татварын талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, улмаар засгийн газар бүхэлдээ татварын ажлын хэрэгжилтийг дэмжихэд нөлөөлөх болов уу. Өмнө дурдсан их сургуулийн судлаачдын судалгааны ажлыг дэмжих тогтолцоо бүрдэж чадах юм. Жишээлбэл, их дээд сургуулиудын окутан судлаачдын санаа бодолд тулгуурласан судалгааг улсад ашигтай санал байна гэж үзвэл энэхүү байгууллага түүнийг албан ёсны судалгааны сэдвээр хүлээн зөвшөөрч баталж өгдөг болговол тэд нар гадаад дотоодын байгууллагатай харилцан хамтран ажиллахад нь тус дэмжлэг болох болов уу. Мөн судлаачдыг энэхүү байгууллагын мэргэжлийн судлаач болгож, түүний судалгааны үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөх, эсхүл их дээд сургуулийн дэргэдэх судалгааны баг бүрэлдэхүүнд тогтсон нэг сэдвээр судалгаа хийлгүүлэх гэх мэт тэдний ажил үйлсэд туслах төрөл бүрийн хэлбэл байж болно. (Судалгааны баг бүрэлдэхүүн буй болгож, энэхүү баг бүрэлдэхүүнд төрийн ажилтныг ямар нэгэн хэлбэрээр татан оролцуулбал татварын албаны ажилтанд ч томоохон туршлага болох ба судалгааны сэдвийн сонголт болон судалгааны чиглэлийг бодит үзэл бодолд тулгуурласан зүйл болгон шийдэхэд хэрэг болно.)

10.2 Татвар төлөгчдөд зориулсан зар суртчилгаа

- (1) Ердийн хүмүүсийн татварын талаарх мэдлэг сонирхлыг дээшлүүлэх үүднээс ҮТЕГ-аас хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээллийг зохион байгуулалттайгаар өгөх замаар татвар төлөх ухамсрыг дээшлүүлэх тал дээр нухацтай арга хэмжээ авах хэрэгтэй байна. Тухайлбал, процессын хуулийн 3-р зүйлийн 3 дахь хэсгийг өөрчилж, татварын алба тодорхой мөнгөн дүнгээс дээш хэмжээний татвар төлсөн татвар төлөгчийг татварын төрөл тус бүрээр мэдээлж, татвар төлөгчдийг мэдээлэх системийг нэвтрүүлэх хэрэгтэй байна. Ялангуяа, татвар төлөгчдийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан зар суртчилгааг идэвхтэй явуулах хэрэгтэй. Энэхүү мэдээллийн системээр татвар төлөгч тэргүүтэй жирийн иргэдийн татварын ухамсар дээшлэхийн зэрэгцээ татвараас зайлхийгчдийг ч бас давхар мэдээлэх тул энэ нь чухал ач холбогдолтой юм.
- (2) Шинээр татвар төлөгчөөр бүртгүүлсэн хүнд жилийн (улиралд нэг удаа) хугацаанд татварын төрөл тус бүрээр татварын сургалт явуулж байхыг процессын хуулинд зааж, тус сургалтын хамт ҮТЕГ-аас зар сурталчилгааны ажлыг шууд хэрэгжүүлэх хэрэгтэй. Энэхүү сургалт, зар сурталчилгаа нь шинэхэн татвар төлөгчтэй шууд харьцаж явуулж буй тул үр дүн гарах нь мэдээж юм.
- (3) Татварын талаар зөв зүйтэй ойлголт бүхий татвар төлөгчдийг төлөвшүүлэн зохион байгуулж, татвар төлөх ухамсрыг дээшлүүлэхэд туслалцаа үзүүлэх бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй. Татвар төлөгчийг зохион байгуулах тал дээр бэрхшээлтэй асуудал олон гарах бөгөөд хэрэгжилт дээр нэлээд төвөгтэй болж мэдэх юм. Боломж бололцоо байвал үтэр түргэн хэрэгжүүлэх ажилд орох хэрэгтэй бөгөөд боломж алдалгүй янз бүрийн төвшинд энэхүү зохион байгуулалтын ажлыг явуулах нь зүйтэй. Энд хамгийн бодитой бөгөөд үр дүнтэй арга бол Улаанбаатар хот дахь үйл ажиллагаа нь сайн явагдаж байгаа татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийг групп болгон зохион байгуулах явдал юм. Тухайлбал, НӨТ-ын нэхэмжлэх бичих нь харилцан итгэлцэл дээр тулгуурлаж байдаг ба энэхүү харилцаанд тулгуурлаж дээрх группын зохион байгуулалтын асуудлыг шийдвэл нэлээд олон тооны аж ахуйн нэгжийг хамруулж чадах юм. Мэдээж, татварын алба энэхүү арга хэмжээг шууд удирдаж хэрэгжүүлбэл «Татвар төлөлтийн урамшуулал нь төрөөс шалтгаална» гэсэн татвар төлөгчийн ухамсартай холбоотой эсэргүүцэл гарч ирж болох юм. Тиймээс жишээлбэл, ҮТЕГ-ын ажилтан бөгөөд томоохон аж ахуйн нэгжүүдийг хариуцсан ТМНБ хүн хувийн секторт ажиллангаа татварын албаны байр суурийг ч бас анхааран үздэг тийм албан ёсны эрх бүхий хүнээр удирдуулж, харин татварын алба түүний ажилд тусалж дэмжих гэсэн байдлаар шийдвэрлэх хэрэгтэй. Ямар ч байсан бүртгэл тооцоог үнэн зөв хийж, татвараа төлдөг татвар төлөгчийн группийг зохион байгуулах нь татвар төлөгчийн өөрийн сайн дураар хийх татварын боловсролын үйл ажиллагаа бөгөөд энэ нь татварын алба ажлыг авч явах гол хүч болж болох юм.

10.3 Бусад арга хэмжээ

Татвар төлөгч татварын албаны ажилтны ажил үүргээ гүйцэтгэж буй байдлыг хэр үнэлж байна вэ, хэрвээ асуудалтай тал бол түүнд үтэр түргэн бөгөөд уян хатнаар хандах нь чухал. Тиймээс татварын албаны ажилтны ажлын гүйцэтгэлийн талаарх татвар төлөгчийн хандлагыг мэдэж, түүнд зохион байгуулалттайгаар шийдвэрлэх арга хэмжээг авах хэрэгтэй.

Учир нь өдөр тутмын ажлаас хяналт шалгалтын ажил хүртэлх татварын албаны ажилтны ажил үүргээ гүйцэтгэх байдал нь өөрөө татварын суртчилгаа юм. Энэ талаар татварын албаны удирдах ажилтан бүрэн ойлголтой байгаа байх. Иймээс энэ талаар ажилтнууддаа дахин дахин ойлгуулах хэрэгтэй. Татвар төлөгч хажуугаас харж үнэлж цэгнэж байгаа шүү гэдгийг бүх татварын албаны ажилтан ухаарч, тэгж ажиллаж сурах хэрэгтэй бөгөөд удирдах ажилтан хүн татварын хяналт шалгалт явагдаж буй байдалд хяналт тавих аргыг боловсруулж гаргаж ирэх хэрэгтэйг энд хэлмээр байна. Хяналт шалгалтын үр дүнгийн хувьд тоо баримтаар хяналт тавих систем бүрэн төлөвшсөн гэж дүгнэж болох ч хяналт шалгалтын явцын талаарх хяналт тун сул байна гэж хэлж болно. Татварын орлогыг богино хугацаанд бүрдүүлэх урамшууллын шинжтэй хяналт ч бас тавих шаардлагатай бөгөөд татварын албаны ажилтны ажил үүрэг гүйцэтгэлийн бодит байдлыг нарийн хянаж, үүнд тулгуурлан ажилтнуудад хяналт тавих нь татвар төлөгчийн татвар төлөх ухамсрыг төлөвшүүлэх, дээшлүүлэхэд тун чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь урт хугацааны татварын орлогын бүрдэлтэнд ч нөлөөтэй гэдгийг удирдах ажилтан хүн илүү ухамсарлах хэрэгтэй юм.

ХАВСРАЛТ

Хавсралт 1

1. Татварын холбогдолтой мэдээ материал цуглуулах ба хяналт шалгалтын бэлтгэл ажлыг хангах нь

1.1 Татварын холбогдолтой мэдээ материал

Монгол улсын аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар нь бусад улс орны жишгийн дагуу татвараа өөрөө тодорхойлох системд тулгуурлан буй болсон ба энэхүү системийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага өөрсдөө татвараа тооцож тодорхойлдог боловч «татварын хяналт шалгалт»-гүйгээр татварын ачааллыг жигд хуваарилах, ард иргэдийн өмчийн эрхийг хамгаалж чадахгүй юм. Улмаар олон нийтийн хэрэгцээ өөрөөр хэлбэл, төрийн санхүүгийн хэрэгцээг хангаж чадахгүй юм.

Өөрөөр хэлбэл, татварын хяналт шалгалт нь орлого татвараа өөрөө тодорхойлох системийн хүрээнд тэгш шударга татвар ногдуулахад их чухал үүрэгтэй тул татварын хяналт шалгалтыг үр ашигтай явуулах нь чухал.

Гэвч Монгол улсад явагдаж буй татварын хяналт шалгалтыг Японыхтой харьцуулахад татварын холбогдолтой мэдээ материал бүрдүүлэх тогтолцоо бүрэн дүүрэн бүрэлдээгүй байна гэж хэлж болно. Үүний улмаас татварын хяналт шалгалтын арга ч мөн адил үр дүн муутай болж байна. Татварын холбогдолтой мэдээ материал цуглуулах, ашиглах явдлыг Монгол улсын татварын албадад нэвтрүүлж чадах юм бол татварын хяналт шалгалт үлэмж үр дүнтэй явагдах боломж нөхцөл бүрдэх юм.

1.1.1 Татварын холбогдолтой баримт материалын хэрэгцээ шаардлага

Татварын холбогдолтой баримт материалын хэрэгцээ шаардлагын талаар тодорхой жишээн дээр тайлбарлая.

Тухайлбал, өнөөдөр та бүхэн А компанид хяналт шалгалт явууллаа гэж үзвэл хаанаас хяналт шалгалтыг эхлэхээ мэдэхгүй байх тохиолдол их гарна. Энэ нь тухайн компанитай холбогдолтой мэдээлэл дутуу дулимаг байгаатай холбоотой. Хэрвээ А компани В компанид хэчнээн хэмжээний борлуулалт хийсэн, А компанийн захирал нь үнэтэй машин унадаг, үнэтэй байр сууцанд амьдардаг гэх мэт мэдээлэлтэй бол харин татварын хяналт шалгалт хийхэд илүү амар дөхөм болох бус уу.

Бүр бодитой жишээ авч үзье. А компани В компанид 1 сая төгрөгийн борлуулалт хийсэн тухай мэдээлэлтэй бол А компанийн татварын хяналт шалгалтаар В компанид хийсэн 1 сая төгрөгийн борлуулалт нь А компанийн бүртгэл тооцоонд тусгагдаж уу үгүй юу гэдгийг мэдэж болно. Бүртгэл тооцоондоо тусгаагүй бол энэ нь татвараас зайлсхийсэн хэрэг болно.

Мөн үнэтэй машин, байр сууц авах хөрөнгийг хаанаас гаргав гэдгийг хөөн шалгавал татвараас зайлсхийж цуглуулсан хөрөнгө мөнгийг илрүүлэх боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, хэрвээ тухайн лүүс ашиг багатай, захирал нь ч мөн адил нэг их орлого олдоггүй бол тийм үнэтэй машин, байр сууц авч чадахгүй нь ойлгомжтой билээ. Эндээс ашиг олж буй хэрнээ түүнээ нуусан, цалин авсан хэрнээ түүнээ тайлагнаагүй гэдэг нь тодорхой болно. Өөрөөр хэлбэл, А компанийн холбогдолтой мэдээллийг урьдчилан цуглуулчих юм бол татварын хяналт шалгалтыг үр дүнтэй явуулж чадах юм. Мөн А компанид татварын хяналт шалгалт явуулахад А компани С компанид төлсөн төлбөр (өөрөөр хэлбэл, зардал) үнэхээр үнэн бодит эсэхэд эргэлзэх тохиолдол гарч ирнэ. Энэ тохиолдолд та бүхэн яах вэ?

Уг нь бол харилцагчид нь шалгалт хийхэд л хангалттай. Гэхдээ харилцагч нь хол оршдог, эсхүл харилцагч компани татгалзах тохиолдол ч гарч ирж мэдэх юм. Ийм тохиолдолд харилцагчид шалгалт хийхэд төвөгтэй болно. Тэгвэл яах вэ?

Тухайн бизнесийн харилцаа (Өөрөөр хэлбэл, А компанийн бүртгэлдээ тусгасан зардал)-г мэдээлэл болгон харилцагч компани (Өөрөөр хэлбэл, С компани)-ийн хяналт шалгалтад ашиглавал ямар вэ?

Харилцагч (Өөрөөр хэлбэл, С компани)-ийн хувьд энэ нь орлого болж бүртгэгдсэн байх ёстой тул С компанийн татварын хяналт шалгалтаар тэрхүү татварын холбогдолтой баримт материалыг ашиглан шалгалт хийж, орлогодоо тусгаж уу үгүй юу гэдгийг шалгах юм. Орлогодоо тусгаагүй бол татвараас зайлсхийсэн, эсхүл А компанийн зардал гэж бүртгэсэн нь хуурамч болох нь тогтоогдоно. Үүнийг хөөн шалгахад л болно. Үүний үр дүнд С компанид орлого болж бүртгэгдэх ёстой зүйл бүртгэгдээгүй байвал С компани татвараас зайлсхийсэн хэрэг болно.

С компанид орлогоор бүртгэх шаардлагагүй зүйл байсан бол А компанийн бүртгэл хуурамч байсан гэсэн үг болох бөгөөд өөрөөр хэлбэл, зардлаа хуурамчаар бүртгэж, татвараас зайлсхийсэн хэрэг болно. Иймээс энэхүү тохиолдолд тухайн холбогдох мэдээлэл (Өөрөөр хэлбэл, А компани зардлаа бүртгэсэн нь хуурамч бөгөөд С компани түүнийг аваагүй)-ийг А компанийн хариуцах татварын албанд мэдэгдвэл заавал харилцагчийн шалгалт хийхгүйгээр А компани татвараас зайлсхийсэн гэдгийг тогтоох сэжүүр олдоно гэсэн үг. Ийнхүү дахин шалгалт хийж, үүнийг үгүйсгэхэд л болно.

Улмаар энэхүү мэдээллийг зөвхөн татварын хяналт шалгалтад бус бэлтгэл шатны шалгалтанд ч ашиглаж болно.

Юу вэ гэвэл, тийм мэдээ материалыг компани компаниар гаргачих юм бол энэхүү мэдээ материал болон тухайн компаниас гаргаж өгсөн тайлан тооцоог харьцуулан үзээд явбал сэжиг бүхий компани аяндаа тодорхой болоод ирнэ.

Тухайлбал, цуглуулсан мэдээ материалаас наад зах нь 1 сая төгрөгийн орлого бүртгэх ёстой байтал тайлан тооцоондоо 500 мянган төгрөгийн л орлогыг бүртгэсэн компани тогтоогдоно. Ийм компанийн хувьд нэн тэргүүнд

шалгалт хийх хэрэгтэй. Мөн цуглуулсан мэдээ материал харъяалагдах эзэнгүй байх тийм тохиолдол гарч ирж болно. Үүнд тэрхүү мэдээ материалд бичигдсэн компани нь тайлан гаргаагүй байх тохиолдол, мэдээ материалын объект болох компани нь огт байхгүй компани ашиглан зардлаа ихээр тооцох гэх мэт тохиолдлыг дурдаж болно.

1.1.2 Бүрдүүлэх мэдээ материалын агуулга ба цуглуулах арга зам

Бүрдүүлэх мэдээ материалын агуулга ба цуглуулах арга замын талаар тайлбарлая.

[1] Ямар мэдээ материал цуглуулах вэ?

Мэдээ материалдаа тухайлбал, компани үүсгэн байгуулахтай холбогдсон бичиг баримт, борлуулалт, худалдан авалт, хэсэгчилсэн бараа буцаалт гэх мэттэй холбогдох баримт материал, бусад аж ахуйн нэгжийн шалгалтаар бүрдүүлсэн баримт материал зэрэг олон зүйлсийг ашиглаж болох бөгөөд татварын албаны ажилтан нь ямар ч боломжийг ашиглан бодит татвар ногдуулалтад шаардлагатай нэмэлт материал бүрдүүлэх ажилд анхаарал хандуулах нь чухал. Эдгээр цуглуулсан татварын холбогдолтой баримт материалаа нийт улс даяар татварын албад харилцан солилцох тийм тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй.

Цуглуулсан мэдээ баримтыг ашиглан санхүүгийн тайлан, татварын тайлан зэргийг хянах нь тус санхүүгийн тайлангийн үнэн зөв эсэхийг тогтооход төдийгүй шалгалтын объектыг зөв сонгоход бэлтгэл шалгалтын үед тун чухал хэрэгтэй юм.

Шалгалт хийх өдөр хоног хязгаартай, аж ахуйн нэгжийн бизнесийн ажил гүйлгээ улам төвөгтэй болох хандлагатай байдаг тул хяналт шалгалтыг үр дүнтэй явуулахад санхүүгийн тайланг нягталж үзэх, шаардлагатай мэдээ материал бүрдүүлэх нь тун чухал. Иймээс хяналт шалгалтын явцад гэх мэт элдэв боломжийг ашиглан хэрэгтэй баримт материал цуглуулж, сонин, сэтгүүл, зурагт, радио зэргээр нэвтрүүлдэг аж ахуйн нэгжүүдийн зар сурталчилгааг ч ашиглаж болох юм.

Цуглуулах баримт материалын агуулга болон цуглуулах арга нь дараах байдалтай байж болно.

1) Албан ёсны баримт материал

Албан ёсны квитанцын систем нэвтэрвэл ҮТЕГ-ын гаргах албан ёсны квитанцид тулгуурлан баримт материал боловсруулах ажлыг үүрэг болгож, баримт мэдээ цуглуулах ажилд хүчээ гаргаж ажиллах хэрэгтэй.

2) Татварын хяналт шалгалтын үе дэх баримт мэдээ цуглуулалт

Татварын хяналт шалгалтын үед хяналт шалгалтын объект төдийгүй татвараа дутуу тайлагнасан байж болох харилцагчид сонголт хийж, ажил гүйлгээний агуулга болон түүний дүн, огноо зэргээр баримт мэдээ цуглуулна. Үүнийг заавал гүйцэтгэх ёстой үүрэгт нь оруулж өгөх нь зүйтэй.

Хүснэгт 1-1

Татварын холбогдолтой мэдээ баримт цуглуулахад ашигладаг маягт

1	Харилцагч
	(1) Аж ахуйн нэгжийн нэр
	(2) Аж ахуйн нэгжийн байршил
	(3) Бүртгэлийн дугаар
2	Ажил гүйлгээний агуулга
	(1) Ажил гүйлгээ явагдсан огноо
	(2) Ажил гүйлгээний агуулга
	① Борлуулалт
	② Худалдан авалт
	③ Зардал
	④ Бусад
3	Мэдээллийн эх сурвалж
	(1) Аж ахуйн нэгжийн нэр
	(2) Аж ахуйн нэгжийн байршил
	(3) Бүртгэлийн дугаар

3) Албан байгууллагаас гаргуулж авах мэдээлэл

Байр сууц худалдаж авах гэх мэт албан байгууллагууд дээр хадгалагдах татварын хяналт шалгалтад хэрэг болохуйц ажил гүйлгээтэй холбоотой бүртгэлийн мэдээ баримтыг цуглуулах хэрэгтэй. ҮТЕГ нь бусад албан газруудтай ажил хэргийн хувьд тийм ч нягт хамтран ажилладаггүй гэж үзэж буй тул үүнийг сайжруулах тал дээр ажиллах хэрэгтэй.

[2] Татварын нотлох баримт цуглуулах ба түүнийг хэрэглэх арга

Татварын хяналт шалгалтын байцаагч нь хожим хяналт шалгалтанд ашиглахаар төрөл бүрийн боломжийг ашиглан бодит татвар ногдуулалтын холбогдолтой мэдээ материалыг баяжуулах, баримтжуулах явдал чухал бөгөөд эдгээр цуглуулсан татварын холбогдолтой мэдээ баримтыг бүх татварын албад харилцан солилцож байх тийм системийг буй болгох хэрэгтэй.

Тухайлбал, мэдээллийг баримт материалд бүртгэж, баримтжуулна. Наад зах нь түүнийг ашиглаж буй газрын нэр, хаяг, утас, ажил гүйлгээний агуулга, мэдээлэл авсан газрын нэр, хаягийг тэмдэглэнэ.

Олж авсан мэдээллийг ашиглах аргын талаар бодитойгоор тайлбарлавал, татварын албадад мэдээлэл баримтыг хариуцан цэгцлэх ажилтан (Мэдээ баримт хариуцагч) ажиллуулах хэрэгтэй. Татварын хяналт шалгалтын үед цуглуулсан мэдээ материалыг тухайн хариуцагч эхлээд тухайн татварын албаны харъяаны, бусад татварын албаны харъяаны гэж ангилна.

Бусад татварын албадын харъяаны зүйлийг ҮТЕГ-т мэдээ материал хариуцагчийг тавьж, тийш нь явуулна. ҮТЕГ дахь мэдээ материал хариуцагчид газар газраас мэдээ материал цугларна. ҮТЕГ дахь мэдээ материал хариуцагч нь тэрхүү цугларсан мэдээ материалыг харъяалах татварын албанд нь явуулна.

Татварын албад дээрх мэдээ материал хариуцагч нь ҮТЕГ-аас ирсэн материал болон тус татварын албаныхаа хүрээнд цуглуулсан материалаас өөрийн харъяа компанийн баримт материалыг нэгтгэж, тэдгээрийг татвар төлөгч бүрээр ангилж, татвар төлөгчдийн «Татвар төлөлтийн хүснэгт»-д файл болгон оруулна.

Мэдээ баримт хариуцагч нь улмаар татварын хяналт шалгалтад шаардлагатай мэдээллийг олж, цуглуулан цэгцэлнэ. Эдгээр мэдээлэл, баримт материал олж цуглуулах тогтолцоог нийт улсын хэмжээнд харилцан өргөн хүрээнд, зохион байгуулалттайгаар бүрдүүлэх хэрэгтэй.

[3] Татварын мэдээ баримтыг ашиглах арга

Цугларсан баримт материалыг эхлээд бэлтгэл шатны шалгалтанд ашиглана.

Татварын холбогдолтой баримт материалыг ашиглан санхүүгийн тайланг нягтлан үзэх нь түүний үнэн зөв эсэхийг тогтооход болон шалгалтын объектын үнэн зөв сонголтод бэлтгэл шатны шалгалтад тун чухал зүйл болох юм. Үүнийг дээр тайлбарласан.

Шалгалтын хоног хугацаа тогтоогдчихсон, аж ахуйн нэгжийн ажил гүйлгээ улам нарийсан төвөгтэй болох тул шалгалтыг үр дүнтэй явуулахад санхүүгийн тайланг нягталж үзэх, мэдээлэл, баримт материал цуглуулах нь үлэмж чухал юм. Иймээс хяналт шалгалтын үед төрөл бүрийн боломжийг ашиглан мэдээ материал цуглуулж, сонин, сэтгүүл, зурагт, радио зэргээр явах компаниудын зар сурталчилгаанаас ч бас мэдээлэл цуглуулж болно.

Энэхүү мэдээлэл, тайлангийн агуулгыг тулгаж шалгаснаар татвараас зайлсхийснийг илрүүлэх сэжүүр олдож магадгүй юм. Энэ нь юу вэ гэвэл мэдээллээр бол борлуулалтын орлогын нийт дүн 2 сая төгрөг байхад тайлан дээр энэ нь 500 мянга байвал борлуулалтын орлогоо нуусан байх

магадлалтай. Гэхдээ хэчнээн их сэжиг бүхий байлаа ч татвараас зайлсхийсэн гэж бүрэн үзэж болохгүй юм.

Мэдээ материал гаргаж өгсөн газар нь алдаатай мэдээлэл өгсөн байж ч магадгүй. Иймээс иймэрхүү компанийг нэн түрүүнд газар дээрх шалгалтад хамруулах хэрэгтэй. Энэхүү газар дээрх шалгалтаар тэрхүү мэдээ материалын агуулгыг шалгана.

Энэ хүртэл мэдээ материалын талаар авч үзлээ.

1.2 Бэлтгэл шалгалт

Ингээд бэлтгэл шатны шалгалт (конторын шалгалт)-ын талаар авч үзье.

1.2.1 Бэлтгэл шалгалтын ач холбогдол

Энэ шалгалт нь татвараас зайлсхийсэн байж болох компаниудаас сонголт хийх зорилготой бөгөөд тухайн аж ахуйн нэгж дээр газар дээр нь очоод шалгалт явуулах бус, харин татварын албан дээр конторт хийх тул конторын шалгалт гэж ч нэрлэдэг. Бэлтгэл ажлын хүрээнд анализ шинжилгээг сайн хийж, мэдээлэл сайн цуглуулж чадвал тэр хирээр шалгалтын ажлын үр дүн нэмэгддэг.

1.2.2 Бэлтгэл шалгалтын зорилго

Бэлтгэл шалгалт нь шалгалтад хамрагдах аж ахуйн нэгжүүдийн тайлан зэрэгт гарах сэжигтэй зүйлсийг илрүүлж, тэрхүү зүйлсийн талаар газар дээрх шалгалтыг хийх үед илүүтэй анхаарч, цаг алдахаас сэргийлснээр шалгалтын үр ашигтай байдалд нөлөөлдөг.

Иймээс шалгалтад хамрагдаж буй аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн татварын тайлангуудыг хянан үзэж, татварын албан дээр цугларсан төрөл бүрийн мэдээ материалыг ашиглан тэрхүү шалгалтад хамрагдаж буй аж ахуйн нэгжийн талаар ерөнхий төсөөллийг олж авч, «юу»-г «хэрхэн» шалгах вэ гэсэн шалгалт явуулах стратеги, үе шат, төлөвлөгөөг сайтар гаргана. Мөн аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар, НӨАТ-ыг нэгэн зэрэг шалгах замаар бэлтгэл шалгалтыг хийх хэрэгтэй.

Бэлтгэл шалгалт нь хязгаарлагдмал цаг хугацаанд явагддаг бөгөөд энэхүү шалгалт хэр үр дүнтэй явагдсанаас дараагийн шатны шалгалтын явц, үр дүн ихээхэн шалтгаална гэдгийг сайтар анхаарч, ул суурьтай явуулах хэрэгтэй.

1.2.3 Бэлтгэл шалгалтын үе шат

Бэлтгэл шалгалт нь тухайн хэргийг шалгалтад хамруулах болсон шалтгааныг харгалзан үзсэний үндсэн дээр тухайн санхүүгийн жилийн тайлан зэргийг тал бүрээс нь хянан үзэж, эргэлзээ бүхий зүйлс болон тэр

дотроос анхаарах ёстой зүйлүүдийг гаргаж ирэхийн зэрэгцээ шалгалтыг үр дүнтэй явуулах арга замыг тогтооно.

Тэрхүү арга зам нь дараах байдалтай байж болно.

- 1) Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тайлан, «татвар төлөлтийн хүснэгт» зэргээс аж ахуйн нэгжийн аж ахуйн үйл ажиллагааны агуулга болон ерөнхий төлөв байдал, татварын талаарх ойлголт, удирдлагын зан төлөв гэх мэтийг тогтооно.
- 2) Санхүүгийн тайланд тусгагдах зүйл болон дансны нарийвчилсан тайлан дотроос гол гол дансыг урьдах санхүүгийн улирлынхтай харьцуулан үзэж (өмнөх улирлын дүнг улаанаар тэмдэглэх гэх мэт), түүнд гарсан өөрчлөлтийг хянана.
- 3) Борлуулалтын нийт орлого, барааны эргэлтийн дүн гэх зэрэгт санхүүгийн шинжилгээ хийнэ.
- 4) Аж ахуйн нэгж байгууллагын татвар төлөлтийн хүснэгтээс өнөөг хүртэлх хугацааны татварын тайлагналын байдал, шалгалт, удирдаж чиглүүлсэн эсэх талаар хянана.

Энэхүү хяналт шалгалтаар газар дээрх шалгалт явуулах уу эсвэл тухайн жилд шалгалтыг явуулахаа болих уу гэдгийг шийднэ.

Иймээс юуны өмнө

- (a) хууль бус үйл ажиллагаа явуулсан талаарх мэдээлэл, хяналт шалгалтын материал бүрдсэн
- (b) Үйл ажиллагааны цар хүрээ үлэмж тэлж байгаа,
- (c) Хэрэг бүртгэлд хамрагдаж буй этгээдтэй бизнесийн харилцаа бүхий аж ахуйн нэгжээс эхлэн сонголт хийнэ.

Дараа нь аж ахуйн нэгжийн тушаасан санхүүгийн тайлан болон «татвар төлөлтийн хүснэгт¹» зэрэгт тулгуурлан түүний ажил үйлчилгээний агуулга, улмаар «харьцааны шинжилгээ» зэргийн «Татварын шинжилгээ (үйл ажиллагааны шинжилгээ²)» зэргээс онцгой тоон үзүүлэлт, алдаа бүхий үзүүлэлтийг олж, хянана.

Үүний тулд «Татвар төлөлтийн хүснэгт» дээр аж ахуйн нэгжийн өнөөг хүртэлх хугацааны татварын тайлагналын байдал, татварын хяналт шалгалттай холбоотой зүйлсийг бичиж, үүнийг үндэслэн аж ахуйн нэгжийг 3 шатлалд хуваан (цаашид «чанарын хяналтын ангилал» гэх³), улмаар борлуулалтын орлогын их багаар ангилж (цаашид «борлуулалтын орлогын шатлалын ангилал⁴» гэх), татвар төлөгчдөд хяналт тавина. Өөрөөр хэлбэл, хяналт шалгалтын үр дүнг дээшлүүлэхийн тулд хяналт шалгалтын

¹ 1.2.5 (1) -ыг үзнэ үү

² 1.2.3 (4)-ыг үзнэ үү

³ 1.2.5 (2)-ыг үзнэ үү

⁴ 1.2.5 (3)-ыг үзнэ үү

сонголтыг хийхдээ доор өгүүлэх чанарын хяналтын ангилал, борлуулалтын орлогын шатлалаарх ангиллыг үр дүнтэйгээр хамтад нь хэрэглэх хэрэгтэй. Энэ тохиолдолд эдийн засгийн байдалд дүн шинжилгээ хийх замаар үйл ажиллагааны гүйцэтгэл сайтай салбарт сонголт хийж, (цаашид «Тогтоосон салбарт шалгалт явуулах хэлбэр» гэх⁵), эдгээрийг нийтэд нь дүгнэснийхээ дараа сонголт хийнэ.

- Одоо (1) Татвар төлөлтийн хүснэгтээр хийх хяналт
- (2) Мэдээ материалд тулгуурласан хяналт
 - (3) Холбогдох үзүүлэлтээрх хяналт шалгалт
 - (4) Татварын дүн шинжилгээгээрх хяналтын талаар авч үзье.

(1) Татвар төлөлтийн хүснэгтээрх хяналт

«Татвар төлөлтийн хүснэгт» гэдэг нь татвар төлөгчийн татвар төлж ирсэн байдлыг хүснэгтээр харуулсан зүйл бөгөөд өнгөрсөн хэдэн жилийн хугацаан дахь тухайн татвар төлөгчийн санхүүгийн холбогдолтой тоон үзүүлэлт бичигдсэн байдаг тул дараалсан хэдэн жилээр харьцуулалт хийж болох бөгөөд мөн өнгөрсөн хугацаанд хийгдсэн татварын хяналт шалгалтын талаарх гол гол зүйлс бичигдсэн байдаг.

Газар дээрх хяналт шалгалтад хамрагдагчийн татварын тайлан болон татвар төлөлтийн хүснэгт нь бэлтгэл шалгалтын үеэр татварын хяналт шалгалтын хэсгийн хянагчид ирэх бөгөөд хянагч нь түүнд байгаа онцгой тоон үзүүлэлт бүхий болон алдаа бүхий газрыг хянаж цэгцлэн, засвар оруулж, тус зүйлийн чухлын зэргийг тогтооно. Бэлтгэл шалгалт дуусангуут татварын тайланг «газар дээрх хяналт шалгалт хийх шаардлагатай», «шалгалт хийх шаардлагагүй» гэсэн хоёр хэсэгт хуваана. Бүх аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт явуулна гэдэг боломжгүй бөгөөд мөн ийм ч шаардлага байхгүй юм.

Энэ мэтчилэн бэлтгэл шалгалтын үр дүнг газар дээрх шалгалт явуулах шаардлагатай ба шаардлагагүй гэж хувааж, татвар төлөлтийн хүснэгтэд бичиж дууссаны дараа газар дээрх шалгалтын ажлын төлөвлөгөөг гаргана.

(2) Мэдээ материалд тулгуурласан хяналт

Татварын тайлагналын зохих төвшинг хангахын тулд зүй зохистой, нарийн шалгалтын зэрэгцээ татвар төлөгчийн ажил гүйлгээ, хөрөнгийн талаарх мэдээ материал цуглуулах явдал зайлшгүй шаардлагатай. Үүний талаар 1.2.5(2)-т дараа авч үзэх болно.

Аж ахуйн нэгжид газар дээрх хяналт шалгалт явуулахдаа бусад аж ахуйн нэгжтэй хийсэн бөгөөд татвараа багасгаж тайлагнасан байж болох ажил гүйлгээг баримтжуулах гэх мэт төрөл бүрийн боломж бололцоог ашиглан

⁵ 1.2.5 4)-ыг үзиг үү

ашиглагдаж болох мэдээ материалыг цуглуулах хэрэгтэй ба сонин сэтгүүл, зурагт радио гэх мэт хэвлэл мэдээллийн хэрэгслээр явах аж ахуйн нэгжийн зар суртчилгаанаас ч мөн мэдээлэл олж авах хэрэгтэй.

(3) Холбогдох үзүүлэлтээрх хяналт шалгалт

Холбогдох үзүүлэлт гэдэг нь тухайлбал, борлуулалтын орлого болон борлуулалтын нийт ашиг, худалдан авалт болон борлуулалтын нийт ашиг, эсхүл худалдан авалт болон худалдан авалтын тээврийн зардлын уялдаа холбоо зэргийг хянах арга юм.

Борлуулалтын орлоготой харьцуулахад нийт борлуулалтын ашиг доогуур бол

- борлуулалтын дүн бичигдээгүй орхигдож уу,
- бодит бус худалдан авалт бичигдэж үү,
- бараа материалын бүртгэл дутуу хийгдэж үү гэдгийг хянаж үзэх хэрэгтэй.

Гэхдээ үнэ буурсан борлуулалт хийгдсэн, худалдан авах үед үнэ өссөн, бараа материалын хэмжээг багасгасан гэх мэт шалтгаан буй бол энэ нь зүй зохистой хэрэг тул санхүүгийн тайлан тооцоо гаргасан бол түүнийг нь урьдчилан татварын албан дээр шинжлэн шалгах хэрэгтэй бөгөөд болж өгвөл татвар төлөлтийн хүснэгтэнд энэхүү дүн шинжилгээний дүнг бичих нь зүйтэй юм.

Борлуулалтын орлого болон үйлдвэрлэлийн хэмжээг харьцуулан үзэж, боловсон хүчний зардал болон ажил гүйцэтгэлийн зардал ихтэй бол

- Борлуулалтын орлого бүртгэгдээгүй орхигдсон эсэх
- Ажиллах хүчний зардал болон ажил гүйцэтгүүлсний зардлыг нэмж бүртгэсэн эсэх зэрэгт анхаарах хэрэгтэй юм.

Ямар ч байсан «Аж ахуйн үйл ажиллагаа нь тодорхой нэгэн багцаалсан тооцооллын үндсэн дээр явагдаж байдаг бөгөөд өөрөөр хэлбэл, тодорхой хэмжээний ажиллах хүчний зардал төлсөн бол аж ахуй эрхлэгч нь хэдий хэмжээний үйлдвэрлэл явуулахаа мэдэж төлөвлөсөн байдаг бөгөөд тодорхой хэмжээний ажил гүйцэтгэлийн зардал төлсөн тохиолдолд эндээс хэдий хэмжээний ашиг гарах вэ гэдгийг дотроо тооцоолж байдаг. Мөн худалдан авалт хийх үедээ тээврийн зардал төлсөн бол нийтийн жишгийн дагуу төлбөр хийсэн байх нь ойлгомжтой.

Иймээс өмнөх улирлуудын тоон үзүүлэлттэй харьцуулахад тэгтлээ нэг их ялгаатай тоо гэнэт гараад ирнэ гэж байхгүй, мөн ижил төрлийн ажил үйлчилгээ эрхлэгчидтэй харьцуулаа ч нэг их хол зөрүүтэй тоо гарахгүй. Хэрвээ хол зөрүүтэй тоо гарвал эхлээд борлуулалтын орлогыг хасч бүртгэж үү, худалдан авалтыг илүү бүртгэж үү, эсхүл зардлыг нэмж тооцож уу үгүй юу гэдэгт анхаарлаа хандуулж, татварын дүн шинжилгээ ч юмуу татварын хяналт шалгалт хийх нь зүй ёсны хэрэг юм.

(4) Татварын шинжилгээний арга

Татварын шинжилгээний аргыг «харьцааны арга» ба «харьцуулалтын арга» гэж хувааж болох бөгөөд жишээлбэл, цэвэр борлуулалтын орлого (нийт борлуулалтын орлогоос борлуулалтын үнэ бууралт, бараа буцаагдалтын дүнг хасаад гарсан дүн)-д борлуулалтын нийт ашгийг хуваагаад гарсан нь борлуулалтын нийт ашгийн харьцаа бөгөөд энэ нь бага бол

- борлуулалтын орлогыг дутуу бүртгэсэн эсэх,
- худалдан авалтыг нэмж бичсэн эсэх,
- бараа материалын хэмжээг хассан эсэх зэрэгт анхаарал хандуулах хэрэгтэй.

Энэхүү борлуулалтын нийт ашгийн харьцааны эсрэг үзүүлэлт нь борлуулалтын өртгийн харьцаа гэдэг нь ойлгомжтой юм.

Мөн цэвэр борлуулалтын орлогод хөдөлмөрийн зардлыг хуваасан нь хөдөлмөрийн зардлын харьцаа болох бөгөөд ажил гүйцэтгэлийн зардлыг хуваавал ажил гүйцэтгэлийн зардлын харьцаа гарна. Тухайн харьцаа өндөр гарвал хөдөлмөрийн зардал нэмж бичигдсэн эсэх, ажил гүйцэтгэлийн зардал худал бичигдсэн эсэх зэрэгт дүн шинжилгээ хийх хэрэгтэй.

«Харьцааны арга» гэдэг нь энэхүү харьцааг өмнөхтэй нь харьцуулж, ижил төрлийн ажил үйлчилгээ гүйцэтгэгчийнхтэй харьцуулахыг хэлэх бөгөөд «харьцуулалтын арга» гэдэг нь тоон үзүүлэлтийг өмнөхтэй нь харьцуулах арга юм.

(5) Жишгээр тогтоох шалгалтын арга

Бэлтгэл шалгалтын үед бүртгэлд тусгагдсан орлогын дүн зөв эсэхийг батлахын тулд жишиг үзүүлэлтийг хэрэглэх хяналт шалгалтын арга юм. Өөрөөр хэлбэл, объектив бөгөөд оновчтой арга, шалгуураар тогтоогдсон жишиг үзүүлэлт болон санхүүгийн тайлан дахь үзүүлэлтийг харьцуулан шалгаж, түүний хооронд зөрүүтэй тоон үзүүлэлт буй эсэх болон тусгагдсан үзүүлэлт үнэн зөв эсэхийг шалгана.

Энэхүү орлогын дүнг жишгээр тооцоолох хяналт шалгалтын аргад оновчтой бөгөөд тохиромжтой дараах аргуудыг дурдаж болно. Үүнээс гадна амьжиргааны дундаж зардалд тулгуурлан урвуулж жишгээр тооцох «амьжиргааны зардлыг урвуулж тооцох арга», нэг нутаг дэвсгэрт ижил төрлийн ажил үйлчилгээ эрхлэгчийнхтэй жишгээр харьцуулж тооцох «ижил төрлийн ажил үйлчилгээ эрхлэгчтэй харьцуулах арга» гэх зэрэг байдаг.

1) Цэвэр хөрөнгийн өсөлт бууралтын арга

Тайлант хугацааны эцсийн хөрөнгөнөөс өр төлбөрийг хассан цэвэр хөрөнгөнөөс тайлант хугацааны эхний цэвэр хөрөнгийг хасч, түүний

өөрчлөгдөлтийн зөрүүг тайлант хугацааны явцын орлого гэж үзэх арга юм. Өөрөөр хэлбэл, «хөрөнгийн арга»-аар орлогыг шалгах арга юм. Энд бид үүнийг «цэвэр хөрөнгийн өөрчлөгдөлтийн арга» гэж нэрлэнэ. Гэхдээ энэхүү аргын үед тайлант хугацааны эхний болон эцсийн хөрөнгө, өр төлбөрийн бодит дүнг гаргах тал дээр техникийн шинжтэй бэрхшээл гардаг. Иймээс энэ нь одоо энд тайлбарлах гэж буй орлого зарлагын хүснэгт гэж нэрлэгдэх «орлого зарлагын арга»-тай хамт хэрэглэгдэх дагалдах арга гэхээсээ илүү үр ашигтай жишиг тооцооны арга юм.

2) Орлого зарлагын хүснэгт

Орлого болон зардал нь бэлэн мөнгө ба хадгаламжийн байдлаар орсон болон гарсан байвал тэрхүү орлого ба зардлыг үндэслэн аккурал зарчмаар нэмэлт болон засвар хийж, орлогын хэмжээг жишгээр тооцон гаргаж болно. Мөн орлого болон зардлын аль нэг нь зөв гэж тогтоогдсон бол тодорхойгүй байгаа болон төгс бус хэсгийг жишгээр тооцох болон харьцуулан үзсэнээр зүй зохистой гэж үзэгдэх орлогын хэмжээг тогтоож болно. Тэрхүү орлогын жишиг дүнг ашиглан тайланд тусгагдсан орлогын дүн үнэн зөв эсэхийг шалган тогтоох хяналт шалгалтын аргыг энд «орлого зардлын арга» гэж нэрлэе.

Өөрөөр хэлбэл, «орлого зардлын арга»-аар орлогын хэмжээ үнэн зөв эсэхийг шалгах бөгөөд дээр дурдсан «цэвэр хөрөнгийн өөрчлөгдөлтийн арга»-тай хавсран хэрэглэснээр илүү үр дүнд хүрнэ.

3) Үр ашгийн арга

Тодорхой нэг «үр ашиг» болон «орлогын дундаж хувь хэмжээ»-гээр орлогын дүнг жишгээр тогтоож, тайланд тусгагдсан мөнгөн дүн үнэн зөв эсэхийг шалгах хяналт шалгалтын арга бэлтгэл шалгалтад өргөн хэрэглэгддэг. Энэхүү хяналт шалгалтын аргыг энд «үр ашгийн арга» гэж хэлэх болно.

«Үр ашиг» гэдэг нь ажилтны тоо, техник хэрэгслийн тоо, талбайн хэмжээ гэх мэт гадаад хүчин зүйлийн орлогын хэмжээнд нөлөөлөх үр нөлөөний хэмжээг хэлэх бөгөөд тухайлбал, нэг ажилтанд ногдох борлуулалтын хэмжээ, нэг техник хэрэгсэлд ногдох борлуулалт, талбайн хэмжээнд ногдох борлуулалтын орлого гэдгээр илэрхийлэгддэг. Өөрөөр хэлбэл, «үр ашиг» гэдэг нь борлуулалтыг жишгээр тооцох үндэс болох зүйлийн нэгж бүрээр тооцож гаргасан борлуулалтын орлогын хэмжээг хэлнэ.

«Дундаж орлогын хувь хэмжээ» гэдэг нь борлуулалтын орлогын дүнд тулгуурлан орлогын хэмжээг жишгээр тооцон гаргахын тулд ижил төрлийн ажил үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааны бодит үзүүлэлтийг дундажчилсан орлогын хувь хэмжээ юм.

Бэлтгэл шалгалтын үед эдгээр аргыг хэрэглэж, тайланд тусгагдсан борлуулалтын орлогын дүн болон ашгийн дүн зэргийн үнэн зөв эсэхийг

шалгана. «Бэлтгэл шалгалтын хүснэгт»-ээр гарах үр ашиг зэргээр орлогын хэмжээг шалгах нь үүнд хамаарна.

«Үр ашгийн арга»-д хэрэглэгдэх бөгөөд борлуулалтын орлогыг жишгээр тооцох гол үзүүлэлт болж чадах зүйлсэд хялбархан олж тогтоож болох ба борлуулалтын орлоготой нягт холбоотой зүйлсийг сонгож оруулсан байдаг. Иймээс энэ нь ажил үйлчилгээний чиглэлээс хамаарч өөр өөр байх бөгөөд ерөнхийд нь хэлэх бололцоогүй тул зөвхөн гол гол зүйлсийг энд дурдая.

Хүснэгт 1- 2 Ажил үйлчилгээний чиглэл бүрээрх үр ашгийн жишээ

Ажил үйлчилгээний төрөл	Гадаад хүчин зүйл	Үр ашиг
Барилга	<ul style="list-style-type: none"> - Ажилтны тоо - Хөдөлмөрийн зардал - Түүхий эд материал зарцуулалтын хэмжээ - Материалын зардал - Барих талбай 	<p>Нэг ажилтанд ногдох барилгын ажлаас орох орлого</p> <p>Нэгж хөдөлмөрийн зардалд ногдох барилгын ажлын орлого</p> <p>Нэгж материал зарцуулалтын хэмжээнд ногдох орлого</p> <p>Нэгж материалын зардалд ногдох барилгын ажлын орлого</p> <p>Барилгын ажлын 10м²-д ногдох орлого</p>
Боловсруулах үйлдвэрлэл	<ul style="list-style-type: none"> - Ажилтны тоо - Гол гол техникийн тоо - Цахилгаан зарцуулалтын хэмжээ - Материал зарцуулалтын хэмжээ - Техник засварын зардал 	<p>Нэг ажилтанд ногдох борлуулалтын орлого</p> <p>Гол үүрэг бүхий нэг техникэд ногдох борлуулалтын орлого</p> <p>1 киловатт цахилгаанд ногдох борлуулалтын орлого</p> <p>Нэгж материалын зарцуулалтад ногдох борлуулалтын орлого</p> <p>Нэгж техник засварын зардалд ногдох борлуулалтын орлого</p>
Бөөний худалдаа	<ul style="list-style-type: none"> - Ажилтны тоо - Барилгын талбай - Үйлчилгээ явуулах өдрийн тоо - Бараа материал - Ачаа тээврийн зардал 	<p>Нэг ажилтанд ногдох борлуулалтын орлого</p> <p>10м² талбайд ногдох борлуулалтын орлого</p> <p>Ажлын нэг өдөрт ногдох борлуулалтын орлого</p> <p>Нэгж бараа материалд ногдох борлуулалтын орлого</p> <p>Нэгж ачаа тээврийн зардалд ногдох борлуулалтын орлого</p>
Жижиглэнгийн худалдаа	<ul style="list-style-type: none"> - Ажилтны тоо - Борлуулалтын талбай - Үйлчилгээ явуулах өдрийн тоо - Бараа материал - Баглаа боодол 	<p>Нэг ажилтанд ногдох борлуулалтын орлого</p> <p>10м² талбайд ногдох борлуулалтын орлого</p> <p>Ажлын нэг өдөрт ногдох борлуулалтын орлого</p> <p>Нэгж бараа материалд ногдох борлуулалтын орлого</p> <p>Нэгж баглаа боодолд ногдох</p>

	зарцуулалтын хэмжээ	борлуулалтын орлого
Хоол, цайны газар	<ul style="list-style-type: none"> - Ажилтны тоо - Суудлын тоо - Тусгай өрөөний талбай - Үйлчлүүлэгчийн тоо - Үйлчилгээ явуулах өдрийн тоо - Гэрэл цахилгааны зардал - Усны зардал 	<ul style="list-style-type: none"> Нэг ажилтанд ногдох борлуулалтын орлого Нэг суудалд ногдох борлуулалтын орлого Нэг өрөөнд ногдох борлуулалтын орлого Нэг үйлчлүүлэгчдээс орох орлого Ажлын нэг өдөрт ногдох орлого Нэг киловатт цахилгаанд ногдох орлого Нэгж усанд ногдох орлого
Тээвэр	<ul style="list-style-type: none"> - Машин техникийн тоо - Ажилтны тоо - Шатахуун зарцуулалтын хэмжээ - Гүйлтийн тоо давтамж - Засварын зардал - Шатахууны зардал 	<ul style="list-style-type: none"> Нэг машинд техникт ногдох тээврийн орлого Нэг ажилтанд ногдох орлого Шатахууны нэгж зарцуулалтад ногдох орлого 10 км-ийн гүйлтэд ногдох орлого Засварын нэгж зардалд ногдох орлого Шатахууны нэгж зардалд ногдох орлого

Иймэрхүү байдлаар бэлтгэл шалгалтыг явуулж, асуудалтай талыг гарган ирж, татварын хяналт шалгалтад бэлддэг байна.

1.2.4 Сонгох шалгуур

Дээр өгүүлсэнчлэн аж ахуйн нэгжийн татварын тайлан болон татвар төлөлтийн хүснэгт зэргийг шалгуур болгон хяналт шалгалтанд хамрагдагчийн сонголтыг явуулах бөгөөд энэхүү тохиолдолд «сонголтын шалгуур» болох зүйлийг урьдчилан тогтооно.

Эхний шалгуурт хамаарах тохиолдолд заавал газар дээрх шалгалт явуулна. Үүнд шууд л «бэлтгэл шалгалтын хүснэгт» ашиглаж, бодитойгоор шинжилгээ хийж хянана.

Шалгалт хийх чухлын шинжээр хоёрдугаарт орох зүйлийн хувьд түүнийг уян хатнаар ашиглана. Нэг зэрэг бүгдийг нь сонгох бус, тайлангийн дарааллын дагуу нэгтгээд чухлын зэрэг өндөртэйгөөс нь шалгалт хийж эхлэх арга ч бий. Иймээс чухлын зэрэг бага зүйлийг тэр хэвээр нь үлдээж, шалгалтын бодит үр дүн гэх мэт зүйлээс шалтгаалаад шалгалтыг явуулахгүй байх, эсхүл шалгалтыг хойшлуулах тохиолдол ч бас гарч болно.

Сонголтод эхний ээлжинд хамрагдах зүйлийг дурдвал дарах зүйлс байж болно.

- ① Зөрчил бүхий ажил гүйлгээний талаар мэдээлэл ирсэн
- ② Бусад этгээдэд явуулсан газар дээрх хяналт шалгалтаар сонин сэтгүүлийн зар мэдээнээс харахад зөрчил бүхий ажил гүйлгээ явуулсан байж мэдэх

- ③ Тайлан гаргаагүй тохиолдолд
- ④ Тайлан тооцооны бичиг баримтанд тусгагдсан тоон үзүүлэлт нь зохиомол зүйл болох нь тогтоогдох үед
- ⑤ Үйлдвэр, дэлгүүр гэх мэт барилга шинээр барих зэргээр үйл ажиллагааны хүрээ нь үлэмж өргөжиж буй тохиолдолд
- ⑥ Тухайн тайлант хугацаанд урьд байгаагүй тоон үзүүлэлт гарсан ба түүний шалтгаан тогтоогдоогүй тохиолдолд

Сонголтын хоёрдахь шалгуурт дараах зүйлс хамаарна.

- ① Бусад аж ахуйн нэгжтэй харьцуулахад орлогын хэмжээ буурсан, эсхүл зардал нь өссөн
- ② Бусад аж ахуйн нэгжтэй харьцуулахад, мөн урьдах улирлуудтай харьцуулахад нийт ашгийн хувь зэрэг нь үлэмж багассан
- ③ Борлуулалтын орлого болон ашгийн хэмжээ ямар ч өөрчлөлтгүй, эдийн засгийн нөлөө тусгагдаагүй тохиолдолд
- ④ Хэд хэдэн удаа (3 жилээс 5 жил)-гийн шалгалт хийгдээгүй, ердийн график шалгалтанд хамрагдаж байсан
- ⑤ Өмнөх шалгалтаар зөгрчилтэй гарсан, татвар төлөлтийн байдал тааруу
- ⑥ Үүсгэн байгуулагдсанаас хойш эхний тайлант хугацаа өнгөрөөгүй тохиолдолд
- ⑦ Төвлөрсөн шалгалт явуулах үйлдвэрлэлийн чиглэлд хамаарах тохиолдолд

Сонгогдсон тайлангуудыг хяналт шалгалтын хэсгийн ахлах хяналтын байцаагч цуглуулж, газар дээрх хяналт шалгалт явуулах шаардлагатай эсэхийг эцэслэн шийдвэрлэж, шалгалтанд хамрагдах аж ахуйн нэгжүүдийг тогтооно.

Эхний сонголт нь заавал ч үгүй газар дээрх шалгалтад хамрагдах ёстой чухлын зэрэглэл өндөртэй зүйлс бөгөөд хоёрдахийн хувьд эхний сонголтын дараа авч үзэх ёстой зүйлс юм.

1.2.5 Бэлтгэл шалгалтын үндсэн бэлтгэл

(1) Татвар төлөлтийн хүснэгт гаргах

«Татвар төлөлтийн хүснэгт» гэдэг нь татвар төлөгчийн татвар төлж ирсэн байдлыг харуулсан зүйл бөгөөд зүйрлэж хэлбэл татварын бүртгэлтэй дүйцэх зүйл юм. Үүнийг татварын хяналт шалгалтын сонголт болон татварын хяналт шалгалтад ашиглагдах материал болгох үүднээс хялбарчлан, эсхүл стандарчилж гаргана.

- 1) Татварын хяналт шалгалтаар хүлээн зөвшөөрөгдөөгүй зүйлс, тайлангийн агуулгыг «татвар төлөлтийн хүснэгт»-д бичиж, тухайн аж ахуйн нэгжид холбоотой баримт материалыг тус хүснэгтэд файл

болгон оруулж, тухайн аж ахуйн нэгжтэй холбоотой мэдээллийг нэгтгэнэ.

- 2) Энэхүү татвар төлөлтийн хүснэгтийг сонголт болон бэлтгэл шалгалтын шатанд ч бус газар дээрх шалгалтын явц болон шалгалтын дараа ч голчлон ашигладаг. Юуны өмнө сонголтын шатанд ерөнхийдөө шалгалтад хамрагдах аж ахуйн нэгжийг сонгоход, бэлтгэл шалгалтын үед шалгалтын төрлийг тогтоох үндсэн материал болгон ашиглана. Мөн цаашдаа компютераар мэдээллийн бааз боловсруулж болно.
- 3) Татвар төлөлтийн хүснэгтэд бичигдэх зүйлсийг боловсронгуй болгох нь

Нэг хуудас зузаан цаасыг 2 нугалж, тус бүрийн ар өвөр талд нь бичих зүйлээ хэвлэн гаргах ба шалгалт эхлэхээс аваад дуусах хүртэлх хугацаанд тогтоогдсон зүйлс болон шалгалт дууссаны дараах үр дүнг ч бас нарийн бичнэ.

(a) Эхний тал

Гол гол барааны талаарх мэдээлэл, ажилтан, тоног хэрэгсэл, удирдлага болон гэр бүлийн байдал, үйл ажиллагааны ерөнхий төлвийг мэдэхэд хэрэгтэй зүйлсийг бичнэ. Өөрөөр хэлбэл, үйл ажиллагааны ерөнхий байдлыг нэг хараад л мэдэж болохоор бичнэ.

(b) Хоёрдахь болон гуравдахь тал

Орлого зарлагын тайлан, балансын үзүүлэлтүүдийг өнгөрсөн хэдэн жилийн хугацаагаар зэрэгцүүлэн харьцуулж болохуйцаар хийнэ. Мөн борлуулалтын нийт ашгийн хувь гэх мэт аж ахуйн үйл ажиллагааны дүн шинжилгээний хувь зэргийг дараалсан хэдэн жилээр харьцуулж болохоор бичихийн зэрэгцээ эргэлзээтэй зүйлсийг тодорхой бичнэ. Өөрөөр хэлбэл, тус хүснэгтэд бичигдсэн тоо, дүн шинжилгээний хувь зэргийг харьцуулснаар санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг мэдэж болохын зэрэгцээ эргэлзээтэй болон онцгой тоо бүхий газрыг олж болохоор хийнэ.

(c) Дөрөвдэх тал

Тайлан гаргахад хэлж зааварчилсан зүйлс, шалгалтын агуулга, түүний үр дүн, дараагийн тайлант хугацааны дараа анхаарах зүйлс гэх мэтийг нарийвчлан бичнэ. Өөрөөр хэлбэл, шалгалтын агуулга болон үр дүнгийн талаар ойлголт авахаар бичнэ.

- (2) Шалгалтын сонголтод «чанарын хяналтын ангилал»-ыг нэвтрүүлэх нь

Өнгөрсөн хугацаан дахь тайлан, татвар төлөлт, шалгалтын үзүүлэлт гэх зэрэг үзүүлэлтэд тулгуурлан бүх аж ахуйн нэгжийн чанарын хяналтын ангиллыг А аж ахуйн нэгж (шалгалт хийх шаардлагагүй), В аж ахуйн нэгж (3 жилээс 5 жилийн хугацаанд ердийн график шалгалтанд хамрагдсан), С аж ахуйн нэгж (Байнгын харилцаатай аж ахуйн нэгж) гэсэн 3 шатлалд хувааж, бэлтгэл шалгалтын шатанд ихээхэн зөрчилтэй гарсан болон сайн үзүүлэлттэй яваа аж ахуйн нэгжид төвлөрсөн шалгалт хийнэ.

(a) А Аж ахуйн нэгж (Шалгалт хийх шаардлагагүй)

Шалгалт явуулах шаардлагагүй аж ахуйн нэгж гэдэгт ① Өнгөрсөн хугацаан дахь аж ахуйн үйл ажиллагааны агуулга болон тайлангийн агуулга нь тодорхой бөгөөд зүй зохистой, ② Өнгөрсөн хугацаанд татварын талаар ямар нэгэн үл хүлээн зөвшөөрөгдөх зүйл гараагүй, ③ Татвараа хойшлуулсан удаагүй, ④ Удирдлага болон тухайн аж ахуйн нэгжийн талаар ямар нэгэн цуу яриа гарч байгаагүй, татвар төлөлтөд идэвхтэй ханддаг, ⑤ Борлуулалтын ангиллаараа доод зэргийн ангилалд хамаарах, ⑥ Сул зогсож байгаа болон татан буугдсан, цаашид тооцоо хийхгүй гэх мэт шалгуурт нийцэх аж ахуйн нэгж орно.

Тухайн аж ахуйн нэгжид үндсэндээ шийдвэр гарснаас хойш 5 жилийн хугацаанд татварын хяналт шалгалт явуулахгүй бөгөөд харин 5 жил өнгөрсний дараа дахин зэрэглэл тогтооно.

(b) В аж ахуйн нэгж (Ердийн графикаар шалгалт хийх)

Ердийн график шалгалтанд хамрагдах аж ахуйн нэгж гэдэгт ① Ердийн график шалгалт болон дахин тайлан гаргах арга хэмжээ удаа дараа авагдсан, ② Тайлангийн дүн нь тухайн чиглэлийн үйлдвэрлэлийн жишигтэй ойролцоо боловч бага зэрэг эргэлзээ төрүүлэхүйц, ③ Удирдлага болон аж ахуйн нэгжийн талаар ямар нэгэн цуу яриа гарч байгаагүй боловч ердийн график шалгалт хийх шаардлагатай гэх мэт шалгуурт нийцэх аж ахуйн нэгж орно.

Тухайн аж ахуйн нэгжид үндсэндээ 3 жилээс 5 жил тутамд газар дээрх шалгалт явуулна. Гэхдээ бэлтгэл шалгалтын үед эргэлзээтэй ба онцгой содон тоо гарч ирвэл, эсхүл зөрчил бүхий мэдээ материал орж ирсэн тохиолдолд газар дээрх шалгалт явуулна.

(c) С аж ахуйн нэгж (Байнга харьцах шаардлагатай аж ахуйн нэгж)

Байнга харьцах шаардлагатай аж ахуйн нэгж гэдэгт ① Өнгөрсөн хугацаан дахь шалгалтаар тайлан тооцоондоо ямагт их хэмжээний дүн бүхий засвар хийх арга хэмжээ авагдаж байсан, ② Зөрчил бүхий тоо болон тайлан ямагт гаргаж болох, ③ Удирдлага болон аж ахуйн нэгжийн талаар ямар нэгэн цуу

яриа гарч байсан, ④ Зөрчил бүхий мэдээ материал үргэлж ирдэг гэх мэт шалгуурт нийцэх аж ахуйн нэгж хамаарна.

Тус аж ахуйн нэгжүүдэд үндсэндээ жил бүр, нэг их асуудал гараагүй үед ч гэсэн татварын хяналт шалгалтыг сайтар явуулах гэх мэтээр ямагт анхааралдаа авч, хяналт тавьж ажиллана.

(3) Шалгалтын сонголтонд «борлуулалтын орлогын ангилал»-ын хэлбэрийг нэвтрүүлэх нь

Борлуулалтын орлогын их багаар аж ахуйн нэгжүүдийг 5 шатлалд хувааж, 1-ээс 2 дахь шатлалыг доод зэрэглэл, 3-аас 4 дэхийг дунд, 5-ыг дээд гэж гурван шатлалд групплэж, дээд шатны аж ахуйн нэгжийг төвлөрсөн шалгалтанд хамруулж, доод шатны аж ахуйн нэгжүүдийг үндсэндээ шалгалтаас чөлөөлнө. Дунд шатныхны хувьд ердийн график шалгалтад хамруулна. Гэхдээ татвараас зайлсхийсэн болон татвараа нуусан гэсэн сэжиг бүхий, эсхүл тэр нь батлагдсан тохиолдолд дунд, доод шатны гэдгээс үл хамааран шалгалтыг хийнэ. Энэ нь цөөхөн тооны татварын байцаагчдыг үр ашигтайгаар ашиглах гэсэнтэй холбоотой юм.

(4) Шалгалтын сонголтод «төвлөрсөн шалгалт хийгдэх гол үйлдвэрлэлийн чиглэл»-ийг тогтоох нь

Гол үйлдвэрлэлийн чиглэлийг тогтоох нь цөөн тооны татварын байцаагчийг үр ашигтай ашиглах арга хэлбэр бөгөөд бүх татвар төлөгчтэй харьцах нь өнөөгийн нөхцөлд боломжгүй зүйл бөгөөд том татвар төлөгч болон татвараас зайлсхийгч, өнгөрсөн хугацаан дахь тайлан, шалгалтын байдал зэргийг харгалзах төдий бус, үр ашигтай гэсэн үйлдвэрлэлийн салбарт голчлон шалгалт явуулах хэлбэр юм.

Гол үйлдвэрлэлийн салбарыг тогтооходоо ихэвчлэн тухайн үед сайн ажиллаж байгаа салбаруудыг шалгалтад оруулах бөгөөд нийт улсын хүрээний асуудлыг ҮТЕГ шийднэ. Харин татварын хэлтэс, албадууд тухайн тухайн бүс нутгийн онцлогтой уялдуулан өөр төрлийн үйлвэрлэлийн салбарт шалгалт явуулдаг.

1.3 Газар дээр шалгалтын арга хэлбэрийг олон төрөлжүүлэх нь

Татвараа өөрөө тодорхойлох системийн нөхцөлд «аж ахуйн нэгжийн тайлагнасан татварын хэмжээ», «татварын шалгалтаар тогтоогдсон татварын хэмжээ» хоёрын хооронд зөрүү үүсэх явдал нь томоохон асуудал юм. Зөрүү үүсэх хэд хэдэн шалтгаан байдаг ба татвар төлөгч болон татварын албаны хоорондох бодит үнэнийг тогтооход гарах зөрүү, хуулийг ойлгож хэрэглэх тал дээр гарах зөрүүний асуудал ихэвчлэн гардаг.

Татвараа өөрөө тодорхойлох систем нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар хэд болохыг өөрөө тооцон гаргаж, татвараа өөрөө тодорхойлон төлөх систем бөгөөд энэхүү системийн тогтолцооны талаар ямар нэгэн

байдлаар үнэлэлт дүгнэлт өгч чадах ч харин татварын хуулийн хувьд асуудал нэлээд төвөгтэй тул бүх хүмүүс үүнийг зөв ойлгож, татвараа үнэн зөв төлнө гэдэг дээр бэрхшээлтэй тал бий. Тиймээс бүх татвар төлөгч татварын хуулийг зөвөөр ойлгож, татвараа үнэн зөв төлнө гэсэн баталгаа байхгүй юм. Мөн татварын хуулийн дагуу тайлан гаргаж, татвараа төлөхгүй байх тохиолдол нэлээд гардаг. Энэ тохиолдолд үүнийг тэр хэвээр нь орхивол татварын эрх тэгш зарчим алдагдахад хүрнэ. Монгол улсад татвараа тайлагнаж төлөхгүй байх явдал өнөөгийн нөхцөлд нэлээд гарч байгаа тул татварын эрх тэгш байдлын зарчим зөрчигдөж эхэлж байна гэж хэлж болно.

Татварын хяналт шалгалтын үндэс нь татвар төлөгчийн гаргасан тооцоо татварын хуулийн дагуу үнэн зөв хийгдсэн эсэхийг тогтооход оршдог бөгөөд үүнийг л тогтоохын тулд татварын хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг. Татварын хяналт шалгалтыг үр ашигтай явуулах шаардлагатай ба үүнд ашиглагдах зүйл нь «Татварын нотолгоо баримтууд» юм. Гэтэл Монгол улсын өнөөгийн татварын албаны ажил хэрэгт татварын нягтлан бодох бүртгэл бүрэн нэвтрээгүй байгаа ба энэхүү татварын нотолгоо баримтын систем бүрэн төлөвшөөгүй байна. Үүний улмаас татварын хяналт шалгалтын арга хэлбэр ч бас үр дүн муутай болж байна. Үүнийг эдийн засаг, нийгмийн бүхэл бүтэн системийн хүрээнд нэвтрүүлээд өгвөл татварын хяналт шалгалт нэлээд үр дүнтэй болох юм. Мөн татвар төлөгчийн хувьд энэ нь татварын хяналт шалгалтад тэдний гаргаж өгөх материал баримт болох бөгөөд үүнтэй уялдан татварын албаны зүгээс татвар ногдуулалтыг үндэслэлгүй хийх явдал байхгүй болно гэдгээрээ давуутай юм.

1.3.1 Татварын хяналт шалгалтын арга хэлбэрийг олон төрөлжүүлэх нь

Татварын хяналт шалгалтаар бүх аж ахуйн нэгжийн татварын тайлан татварын хуулийн дагуу хийгдэж үү үгүй юу гэдгийг шалгаж тогтоох нь чухал бөгөөд бодит байдал дээр татварын албаны ажилтны тоо, цагийн хүрэлцээнээс шалтгаалаад үүнийг хэрэгжүүлэх бололцоогүй байдаг.

Иймээс татварын хяналт шалгалтын төрөл хэлбэрийг олон янзын хэрэглээ, зорилгод нийцүүлэн олшруулах шаардлагатай бөгөөд доор дурсан шиг татварын хяналт шалгалтыг «Албадан шалгалт», «Онцгой шалгалт», «Ердийн шалгалт» болон «Хялбарчилсан шалгалт» гэж ангилан, хэрэглээ зорилгодоо нийцүүлэн ашиглах нь зүйтэй юм.

(1) Албадан шалгалт

Албадан шалгалт гэдэг нь татварын зөрчил гаргасан байж болзошгүй гэсэн эргэлзээтэй бөгөөд үүнийг олж тайлах шаардлагын үүднээс явуулах шалгалт юм. Энэ нь «Хэрэг бүртгэл» гэж нэрлэгдэх бөгөөд үүнд хойно өгүүлэх ердийн шалгалттай адил арга хэрэглэгдэх боловч шүүгчийн зөвшөөрөл авч, ажлын байранд нэвтрэн орж, шалгалт хийж, эд хөрөнгө

хураан авч болдог тийм шалгалтын хэлбэр юм. Татвар төлөгчийн татварын тайлангийн үнэн зөвийг шалгах төдийгүй татварын хяналт шалгалтад хамрагдагчийг прокурорт шилжүүлэх зорилготой.

Урьдчилан мөрдлөг хийж, түүнээс олж авсан баримтад тулгуурлан тухайн аж ахуйн нэгжийн гол болон салбар компани, үйлдвэр, удирдлагын гэрт төдийгүй харилцагч байгууллага, харилцагч банк гэх мэт санхүүгийн байгууллагад нэг мөр шалгалт хийж эхэлнэ. Уг нь бол «Газар дээрх шалгалт явуулж, хөрөнгө хураах зөвшөөрлийн бичиг» үзүүлэн нэлээд албадсан байдлаар энэхүү шалгалтыг явуулдаг.

(2) Ердийн шалгалт

Энэ нь ерөнхий шинжтэй шалгалт бөгөөд татвар төлөгчийн зүгээс үзүүлэх туслалцаа үүнд гол хүчин зүйл болдог. Заавал ч үгүй татвар төлөгчийн зөвшөөрлийг авсны үндсэн дээр санхүүгийн баримтыг нь гаргуулан үзэж, асуулга явуулж, татварын нотолгоо баримтыг хянах шалгалтын хэлбэр юм. Ердийн шалгалт нь эд хөрөнгийн шалгалт, санхүүгийн баримтын шалгалтаар хэрэгжих бөгөөд үүгээр татвар төлөгчийн бодит байдлыг бүрэн мэдэх бололцоогүй.

(3) Онцгой шалгалт

Ердийн шалгалтаар албадан шалгалттай харьцуулахад хангалттай зүйл олж чадахгүй. Тиймээс албадан шалгалт болон ердийн шалгалтын завсрын шинж бүхий шалгалтыг явуулах шаардлага урган гарсан байна.

(5) Хялбарчилсан шалгалт

Хялбарчилсан шалгалтыг явцуу хүрээний шалгалт гэж нэрлэдэг бөгөөд тухайлбал, татвар төлөгчийн тогтсон нэг зүйлийг л шалгадаг байна. Иймээс шалгалт явуулах өдөр хоног нь ч бас бусад шалгалтынхтай харьцуулахад богино байдаг.

1.3.2 Сайн үр дүнтэй ажлын талаар хэлэлцүүлэг хийх

Жил бүр тухайн жил хийгдсэн хяналт шалгалт дундаас шинэлэг арга барил бүхий болон үйлдвэрлэлийн салбарт нийтлэг гарсан зөрчлийг илрүүлсэн тийм шалгалтын талаар татварын албад дээр «сайн үр дүн бүхий ажлын талаарх хэлэлцүүлэг» явуулж, тус тохиолдлын талаар хэлэлцэж, мэдлэг мэргэшлээ хуваалцахын зэрэгцээ тухайн хяналт шалгалтыг хийсэн байцаагчийг сайшаан урамшуулж, цаашид улам сайн ажиллах урам зоригийг өгөхийн зэрэгцээ байцаагчид бие биенээсээ хяналт шалгалтын хийх арга техникийг харилцан суралцах тийм тогтолцоог бүрдүүлнэ.

Үр дүн сайтай, шилдэг хэргийг авч хэлэлцэх хэлэлцүүлэгт хяналт шалгалтыг чиглүүлэх гол зүйлээ зөв олсон, шалгалтын арга техник нь өвөрмөц, нэлээд сэтгэж ажиллаж, үр дүн сайн гарсан хэргийг оруулна.

Бусад ажилтны ажлын ур чадварыг дээшлүүлэх үүднээс тогтсон нэг үйлдвэрлэлийн салбар, хүрээний бус, аль болохоор өргөн хүрээг хамарсан хэргийг энэхүү хэлэлцүүлэгт сонгож оруулах хэрэгтэй.

Татварын байцаагчийн хувьд тухайн хэлэлцүүлэг дээр өөрийнх нь хэргийг танилцуулж, ажлаа тайлагнах боломж олдож байгаа нь нэр төрийн хэрэг гэдэг талаар ҮТЕГ-ын дарга болон татварын албадын дарга нар сайшаан урамшуулж байх хэрэгтэй.

1.3.3 Зөвлөгөө ба удирдамж өгөх тогтолцоог нэвтрүүлэх нь

Зөвхөн татварын хяналт шалгалт бус татвар төлөгчид үзүүлэх зөвлөгөө, удирдаж чиглүүлэх ажлыг ч бас татварын хяналт шалгалттай хамт нэгэн зэрэг явуулж байх хэрэгтэй юм. Татварын мэдлэг хомс татвар төлөгч олон байдаг бөгөөд татварын хяналт шалгалтаар зөрчлийг илрүүлэхээсээ өмнө тийм татвар төлөгчдийг татварын тайлан үнэн зөв гаргаж сургах нь чухал юм. Иймийн тулд татвар төлөгч тайлан гаргах үед мэдэхгүй чадахгүй зүйл гарвал түүнд нь туслах зорилгоор татварын зөвлөгөөг үнэ төлбөргүй өгөх тогтолцоог буй болгох нь зүйтэй.

Тухайлбал, шинээр үүсэн байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллага болон тухайн үйлдвэрлэлийнхээ салбарт бэрхшээлтэй тулгараад байгаа аж ахуйн нэгжийг хамруулан татварын тайланг үнэн зөв гаргах арга, өнгөрсөн хугацаанд олон удаа гарсан татварын талаарх буруу зөрүү ойлголт алдаануудын талаар танилцуулж, цаашдаа тиймэрхүү алдаа гаргахгүй байх талаар зааж чиглүүлж байх хэрэгтэй.

1.3.4. Татварын байцаагчийн ажлын ур чадварыг дээшлүүлэх нь

Төрөл бүрийн сургалт (Татварын нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдлэг, баримт материал цуглуулах арга, татварын нотолгоо баримтыг ашиглах арга, хяналт шалгалт явуулах арга техникийг дэлгэрүүлэх)-аар дамжуулан хяналт шалгалт хийх ур чадварыг дээшлүүлэх тал дээр ажиллах хэрэгтэй. Сайн ажилласан ажилтны хувьд түүний ажлын арга барилаас бусад ажилтанд суралцуулах, түүнийг ноу хау болгон нийтээр ашиглах, өмнө дурдсан сайн үр дүн бүхий хэргийн талаар хэлэлцүүлэг явуулж, тайлагнахын зэрэгцээ ҮТЕГ-ын дарга болон татварын албад, хэлтсийн дарга сайшааж урамшуулж байх хэрэгтэй.

1.3.5. Татвараа тайлагнаагүй этгээдийг илрүүлэх нь

Татвараа тайлагнаагүй этгээдийг олж илрүүлэхийн тулд аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлийн данс бүртгэл, гаалийн газраас ирүүлсэн экспорт, импортын үйл ажиллагаа эрхлэгчдийн жагсаалт, татварын хөнгөлөлт эдэлж буй татвар төлөгчдийн жагсаалт зэргийг ашиглан тусгай шалгалт явуулна.

Дээр өгүүлсэн шалгалтуудын талаар аж ахуйн нэгж байгууллагын жишээн дээр авч үзсэн бөгөөд НӨТ-ыг ч бас нэгэн зэрэг шалгаснаар шалгалтын үр дүн дээшлэх юм.

Татварын нотолгоо баримтад тулгуурлан газар дээрх шалгалтыг явуулах нь

Татварын хяналт шалгалтанд нотолгоо баримт шийдвэрлэх хүчин зүйл болдог. Энэ хэсэгт нотолгоо баримтын татварын хяналт шалгалтанд гүйцэтгэх үүргийн талаар тайлбарлав.

1. Татварын хяналт шалгалтанд нотолгоо баримтын гүйцэтгэх үүрэг

Татварын хяналт шалгалтаар татварын тайлангийн тооцоолол үнэн зөв эсэхийг тогтоохдоо тайлангийн үзүүлэлтийг магадлан тогтоох боломжтой «баримт»-ыг шалгадаг. Өөрөөр хэлбэл, аливаа нотолгоо баримтыг магадлан шалгаснаар татварын тайлан баталгаажиж, татварын хяналт шалгалт дуусгавар болно.

Гэхдээ татварын тайланг шалгахад хэрэг болох баримт дутмаг, эсвэл магадлан тогтоох боломжгүй үед татварын албаны үйл ажиллагаанд хүндрэл үүсдэг. Энэ нь олонхи тохиолдолд татварын хууль тогтоомжийг зохих ёсоор хэрэгжүүлж чадаж буй эсэхээс хамаарч үүсдэг.

Татвараа өөрөө тодорхойлж төлөх систем хэрэгжиж байгаа нөхцөлд татвар төлөгчийн хувьд «мэдэхгүй» гэсэн асуудал гарах учиргүй. Татвар ногдох орлого тодорхойгүй тохиолдолд жишиг татвар ногдуулах, эсвэл татварын тодотгол хийх ёстой. Иймд татварын хяналт шалгалтын явцад гарч болох асуулт болон хяналт шалгалтанд хамрагдах арилжаа гүйлгээний талаар магадлан тогтоох боломжтой нотолгоо баримтыг татвар төлөгч өөрийн зүгээс бэлдэж татварын албанд гаргаж өгөх хэрэгтэй. Энэ нь нэг талаар татвар төлөгч өөрийн эрхийг хамгаалж байгаа хэрэг юм.

2. «Нотолгоо баримт» болон бодит байдлыг магадлан тогтоож үнэлэлт өгөх

Татварын хяналт шалгалтын үндсэн зорилго нь бодит үнэнийг магадлан тогтооход оршдог. Ингэхдээ уг арилжааны нягтлан бодох бүртгэлд тусгагдах байдал болон татварын тооцоонд ашигласан байдлыг шалгана. Ийнхүү шалгахдаа юуны өмнө тухайн аж ахуйн нэгж, байгууллагын өөрсдийн нь тодорхойлсон татвар ногдох орлогыг хөндлөнгөөс дүгнэх болдог. Ийм тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллагын тодорхойлсон татвар ногдох орлого болон татварын хяналт шалгалтаар гаргасан дүгнэлт нь тухайн тухайн зорилго, ашиг сонирхлоос хамааран олонхи тохиолдолд

хоорондоо тохирохгүй байх тохиолдол гардаг тул нотолгоо баримтаар бодит дүгнэлт гаргах шаардлага гардаг.

Бодит байдлыг магадлан тогтооход баталгаа болох зүйл нь «нотолгоо» юм. Шүүхэд уг нотлох баримтыг «гэрчийн этгээдийн мэдүүлэг, эд мөрийн баримт» гэх бөгөөд татварын хяналт шалгалтын явцад бичгийн болон аман баримт (аливаа үйл явдалд өөрийн биеэр оролцсон, эсвэл энэ тухай сонссон этгээдийн бичгээр өгсөн мэдүүлэг) нь чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр нотолгоо баримтыг дор дурдсаны дагуу 2 хэсэгт хуваана.

(1) Үндсэн баримт

Тухайн холбогдох үйл ажиллагааг шууд нотлох баримтыг хэлнэ. Тухайлбал, гэрээ, мэдэгдэл, вексель, шүүхийн шийдвэр, гэрээслэл, гэрээ хүчингүй болгох тухай мэдэгдэл зэрэг баримтууд үүнд хамаарна.

(2) Бусад баримт

Тухайн бичгийг боловсруулагчийн үзсэн сонссон зүйл, сэтгэгдэл, санал, мэдүүлэг зэргийг хэлнэ. Мэдүүлэг нь түүнийг үйлдэгчийн биеэр үзэж харсан бодитой зүйлийг бичгээр илтгэсэн баримт бөгөөд үүнд захидал, тэмдэглэл, арилжааны бүртгэл, хувьцаа эзэмшигчдийн хурлын протокол, удирдах зөвлөлийн хурлын протокол, төрөл бүрийн өргөдөл, акт, баримт, нэхэмжлэх, захиалгын хуудас, барааны падаан, бараа материал нийлүүлсэн баримт, үнийн санал, санал хүсэлт, ярианы тэмдэглэл, санал хураалтын хуудас зэрэг хамаарна.

Татварын хяналт шалгалтын явцад эдгээр бичиг баримтанд голчлон тулгуурласан магадлан тогтоох шалгалтыг тойрон татвар төлөгч болон хяналт шалгалтын байцаагчийн хооронд маргаан мэтгэлцээн өрнөдөг. Ийнхүү шалгалт хийхэд юуны өмнө бодит баримтыг магадлан тогтоох, ойлгож тайлбарлах хэрэг гарах ба уг хоёр асуудлыг тус тусад нь авч үзэх хэрэгтэй юм. Тухайн баримтыг сайтар ойлгосон байх нь магадлан тогтоох шалгалтын үндэс болдог. Иймд татварын бүртгэл болон нягтлан бодох бүртгэл хөтлөх татвар төлөгч нь татварын хууль тогтоомж болон холбогдох тушаал шийдвэрийн талаар сайтар судалсан бөгөөд түүнийг хэрэглэх үндэслэлийг ойлгож мэдсэн байх шаардлагатай.

Түүнчлэн татварын бүртгэлд тухайн арилжаа бодитойгоор тусгагдсан эсэхийг тогтоох үнэлгээний стандартыг боловсруулах хэрэгтэй. Ийнхүү аливаа баримтыг магадлаж тогтоох нь татварын хяналт шалгалтын үндсэн зорилго болох бөгөөд үүний тулд татварын бүртгэлийг баталгаажуулах баримт хэрэгтэй болдог. Гэвч нийгэм эдийн засгийн өнөөгийн байдлаас харахад аливаа бизнесийн үйл ажиллагаа нарийн эздрээтэй бөгөөд олон төрөл хэлбэртэй болж байгаагаас гадна бичиг хэргийн шинэчлэлттэй уялдаад мэдээллийн хэрэгсэл улам боловсронгуй болж олон нийтэд дэлгэрч байгаагаас татварын хяналт шалгалтанд нотолгоо болгож ашиглах баримт бичгийн хамрах цар хүрээ улам тэлсээр байна.

Иймд татварын хяналт шалгалтын явцад ашиг сонирхол өөр харилцагч байгууллагын боловсруулсан гадны эх үүсвэр бүхий баримтыг голчлон нотлох баримт болгодог. Гэхдээ тухайн аж ахуйн нэгжийн дотоод баримт бичиг нь холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулагдсан бөгөөд үнэн зөв, будлиан зөрчилгүй, тухайн арилжаа гүйлгээг шууд бус ч гэсэн тодорхойлох боломжтой бол татварын чухал нотолгоо баримт гэж үзнэ.

3. Татварын нотолгоо баримт болон тайлбар баримт

Татварын хяналт шалгалтаар бодит баримтыг магадлан тогтооход санал зөрөлдөөнтэй асуудал гарахаас зайлсхийх, татварын тайланг хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулах, татварын илүү ачаалал үүсэхээс сэргийлэхийн тулд аливаа арилжаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтлөхийн зэрэгцээ татвар ногдуулах үйл ажиллагаанд хуулийн дагуу зохих ёсоор оролцох хэрэгтэй болдог.

Үүнийг татварын менежмент гэх бөгөөд аливаа арилжаа явагдаж дууссаны дараа, эсвэл арилжааны явцад тус тусад нь хэрэгжүүлэх татварын хэмнэлтээс илүү дэвшилттэй бодлого юм. Энэхүү татварын менежментийг үр дүнтэй болгож байдаг зүйл нь «татварын хяналт шалгалтаар татварын тайланг баталгаажуулахад хэрэгтэй аливаа арилжааны нотолгоо баримт» юм.

Уг нотолгоо баримт нь тухайн үнэ цэнээсээ хамааран хүчин төгөлдөр болох эсэх нь шийдэгдэх ба уг үнэ цэнийг ерөнхийд нь «нотлох чадамж» гэж нэрлэдэг. Хуулийн хэллэгээр «нотолгоо» гэдэг нь шүүгч эсвэл шүүх байгууллагад итгэл төрүүлэхүйц хэмжээний бодит баримтанд тулгуурлан ямарваа нэг баримтыг ил тод болгохыг хэлнэ. Харин «баталгаа» гэж шүүх байгууллагад итгэл төрүүлэхүйц хэмжээнд хүртэл хангалттай нотолгоо болж чадахгүй ч гэсэн үнэн зөв байж магадгүй гэсэн таамаглал төрүүлэхүйц баримтыг хэлнэ.

Татварын хяналт шалгалт нь аливаа хэрэг шүүх, зарга хэлэлцэхээс ялгаатай тул хяналт шалгалтанд нотолгоо болох баримтыг анхнаасаа өөр байр сууринаас авч үздэг ба тухайн бодит баримтын талаар хурдан шуурхай дүгнэлт гаргадаг. Түүнчлэн энэхүү дүгнэлт нь татвар төлөгч, татварын байцаагчийн хооронд явагддаг тул нотолгоо баримт нь бодитой, хамрах цар хүрээ өргөн, тоон үзүүлэлт их байвал үр дүнтэй байдаг. Иймд татварын нотолгоо баримтыг дээр өгүүлсэн «нотолгоо болон баримт»-д тулгуурлан дараах байдлаар тухайн зорилгод нь нийцүүлэн ангилна.

- Татварын нотолгоо баримт
- Татварын батлах баримт
- Татварын тайлбар материал

(1) Татварын нотолгоо баримтын агуулга, зорилго

Уг баримт нь аливаа арилжааг тодорхой болгож, тухайн арилжаанд хамаарах нягтлан бодох бүртгэл бодит байдалтай тохирч байгаа эсэхийг батлах баримт юм. Тухайлбал, өдөр тутмын арилжааны бүртгэл, гэрээ зэрэг баримт үүнд хамаарна. Жишээлбэл, ажил гүйцэтгэсний төлбөрийг бэлэн мөнгөөр төлж баримт авах явдлаас зайлсхийж чекээр төлбөр хийх аргыг хэрэглэх нь харилцагч талын дансанд чек орсныг нягталж болдгоороо олон талын нотолгоо бүхий арилжаа болдог. Иймд татварын нотолгоо баримт гэдэг нь харилцагч талын тамга тэмдэг бүхий баримтыг хэлдэг. Үүнээс гадна арилжаанд оролцогч талын хувьд уг арилжааг баримттай болгож мөн ямарваа нэг гуравдагч этгээдийн байр сууринаас магадлан тогтоож болохуйц баримт гэж хэлж болно. Иймд татварын хяналт шалгалтын явцад аливаа арилжааны талаар тодруулах шаардлагатай асуулт гарсан тохиолдолд дээр дурдсан баримтыг хариу болгож ашигладаг.

(2) Татварын нотолгоо баримтын төрөл түүнд тавих хяналт

Татварын нотолгоо баримтанд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг тэмдэглэсэн арилжааны бүртгэлээс эхлээд үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл хүртэлх бүх төрлийн баримт бүртгэл данс тооцоо орно.

Татварын нотолгоо болох санхүүгийн бүртгэлийн баримт бичгүүд:

1. Журнал, орлого, зарлагын падаан
2. Шалгах баланс, сарын орлогын нэгтгэсэн тайлан
3. Хаалтын тохируулах ажлын хүснэгт
4. Туслах дэвтэр, бүх төрлийн дансны туслах дэвтэр
5. Ерөнхий дэвтэр, тусгай журнал
6. Санхүүгийн тайлан, бүртгэл тооцооны баримтууд
7. Нотолгоо баримтууд
8. Бүх төрлийн хадгаламжийн дэвтэр, векселиэр мөнгө хүлээж авсан баримт, кассын орлого, зарлагын ордер, банкны хуулга
9. Харилцах дансны тулган баталгаажуулах тайлан, үлдэгдлийн тайлан
10. Гэрээ, батлах баримт

Эдгээр баримт нь татварын тайлан гаргахад болон нягтлан бодох бүртгэлийн сахилга бат, удирдлагын үүргийг хэрэгжүүлэх, мөн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад чухал баримт болдог. Иймд худалдааны хууль болон бусад холбогдох хууль тогтоомжинд эдгээр данс бүртгэл хөтлөх үүргийн талаар тодорхой заалт оруулах хэрэгтэй байдаг.

Татварын хяналт шалгалтаар юуны өмнө нягтлан бодох бүртгэлийн зарчим болон тайлан гаргах үүргийн дагуу хөтлөгдөх албан ёсны нягтлан бодох бүртгэл, тайлан балансыг татварын тайлангаар тодорхойлсон татвар ногдуулах дүнг баталгаажуулах баримт болгон шалгадаг. Түүнчлэн тайланд хэрэглэсэн хувийг хуулийн зохих заалттай тохируулан үзэхийн

тулд тайлангийн тооцооллыг нотлох баримтаар магадлан тогтоох шалгалт хийх хэрэгтэй байдаг.

Тайланд тусгасан дүн бодит гүйлгээ арилжаатайгаа тохирч байгаа эсэхийг шалгахдаа гадны эх үүсвэр бүхий арилжааны нотолгоо баримтанд тулгуурладаг.

Татварын нотолгоо баримтын ангилал

1. Мөнгөн гүйлгээний баримт: квитанци, орлого, зарлагын ордер, дансны шилжүүлгийн баримт, чек гэх мэт
2. Бараа таваарын ажил гүйлгээний баримт: барааны падаан, хүлээн авсан баримт, ачуулалтын дэвтэр, барааны дагалдах хуудас гэх мэт
3. Цалин хөлстэй холбоотой ажил гүйлгээ: цалин хөлс, шагналын тооцооны хүснэгт, дундын суутгалын баримт гэх мэт
4. Санхүүгийн арилжааны баримт: банкны тооцооны дэвтэр, баримт, тулган баталгаажуулах тайлан, хадгаламжийн баримт, дансны үлдэгдлийн баталгаа гэх мэт
5. Гэрээний баримт бичиг: гэрээ, контракт, эрхийн бичиг, баталгааны баримт гэх мэт

Эдгээр нотолгоо баримт нь татварын хяналт шалгалтанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хяналт шалгалтын үеэр алдаатай бичилт хийсэн, хагас дутуу хөтөлсөн, зөрчилтэй тайлан балансыг засвар хийхийг шаардаж тайлангаар тодорхойлсон татвар ногдох орлогыг дахин тооцож боддог. Иймд нотолгоо баримтыг дээр дурдсаны дагуу ангилж тус тусын гүйлгээнд хамаарах баримтыг тогтоосны үндсэн дээр цуглуулж хяналт шалгалтанд ашиглах хэрэгтэй. Мөн дээрх гүйлгээ арилжааны нотолгоо баримт нь хангалттай баталгаа болж чадах эсэхийг шалгаж үзэх хэрэгтэй.

(3) Татварын нотолгоо баримтыг шалгах болон хянах

Өдөр тутмын гүйлгээ арилжааны хэмжээ нэмэгдэх тусам татварын нотолгоо баримтын тоо ихэсдэг. Арилжаа тутамд бүртгэл, нотолгоо баримт хэрэглэгддэг хэдий ч цаг давчуу үед эдгээр баримт хөтлөх болон хүлээн авахдаа түүний доторх агуулгыг төдийлөн шалгахгүй байх явдал байдаг.

Эцсийн шатанд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн хэлтэс байгууллагын нягтлан бодох бүртгэл болон хөрөнгийн зарцуулалтанд дотоод хяналт тавьдаг хэдий ч татварын талаас нь төдийлөн шалгадаггүй. Үүний улмаас татварын хяналт шалгалтаар санхүүгийн тайлан балансыг шалгах явцад санаанд оромгүй асуудал гарч ирэх явдал цөөнгүй байдаг. Иймд эдгээр баримтыг татварын тооцоонд нотолгоо баримт болгож үр дүнтэй ашиглахын тулд татвар талаас нь шалгах хэрэгтэй байдаг.

Нотолгоо баримтын дотроос хамгийн чухалд тооцогдох мөнгөн гүйлгээний баримтыг шалгахад анхаарах зүйл

1. Удирдах ажилтны хувийн хэрэглээний зардлыг татвар ногдуулах орлогоос хасагдах зардлын дүнд оруулан бүртгэсэн эсэх
2. Хагас дутуу хөтөлсөн болон буруу зөрүү бичилт хийгдсэн эсэх
3. Баримтанд засвар оруулсан эсэх
4. Сольж янзалсан, хуурамчаар үйлдсэн, мөн дуураймал баримт эсэх
5. Үгсэн тохиролцох боломж бүхий харилцагч байгууллагын хөтөлсөн баримт эсэх
6. Хаяг зөв эсэх, бичвэр тэмдэглэл хийсэн байдал эргэлзээтэй эсэх
7. Огноо нь нягтлан бодох бүртгэлтэй таарч буй эсэх
8. Баримт бичсэн газрын хаяг, нэр, утасны дугаар зөв эсэх
9. Тамга тэмдгийн хэв төрөл болон хэрэглэх арга зөв эсэх
10. Хэрэглэсэн цаас хуурамч, мөн хуучин эсэх, зөв дэс дараалал бүхий дугаартай эсэх
11. Албан ёсны бус цаас хэрэглэсэн тохиолдолд шалтгааныг тодруулах
12. Бүртгэл хийгдсэн өдрөөс хойш хүлээн авсан баримтын шалтгааныг тогтоож, солигдсон эсэхийг шалгах
13. Дугаарын дараалал зөв эсэх

Татварын хяналт шалгалтын үеэр дээр дурдсан асуудалд анхаарал хандуулах хэрэгтэй ба зохих түвшинд санхүүгийн бүртгэл хөтөлдөг газарт мэдээж эдгээр хяналт явагдаж байдаг. Гэхдээ өдөр тутмын санхүүгийн үйл ажиллагааны явцад бүрэн дүүрэн шалгадаг гэж хэлж болохгүй юм. Иймд татварын хяналт шалгалтаар давхар шалгах хэрэгтэй байдаг. Ийнхүү зохих хяналт хийгдсэн баримт нь илүү баталгаатай болдог. Үүнээс гадна эдгээр баримт бичгийг цэгцтэй, тодорхой бөгөөд хэрэглэхэд хялбар үр дүнтэй байхаар хөтлөх шаардлагатай.

(4) Тайлбар баримтын агуулга болон зорилго

Тайлбар баримт нь «нотолгоо баримт»-ыг тодруулах үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ нотолгоо баримтаас илүү аливаа гүйлгээ арилжааны тухай бодит мэдээлэл өгдөг. Тухайлбал, өдөр тутмын ажил төрлийн санамж тэмдэглэл, анхан шатны баримт, санал хураалтын хуудас, хурал зөвлөгөөний тэмдэглэл бүхий тухайн арилжаа гүйлгээний талаар бичсэн баримт болон тайлбар хүснэгт зэргийг хэлнэ. Иймд уг тайлбар баримт нь олон төрөлтэй, хэвшмэл буюу нэг хэв загвартай байдаггүй бөгөөд өргөн цар хүрээг хамардаг. Түүнчлэн шинжлэх ухаан, технологийн хөгжил, бичиг хэргийн шинэчлэлийн үр дүнд бий болсон техник хэрэгслийг ашиглаж тэмдэглэсэн зүйлс ч байж болно.

Ер нь татварын нотолгоо баримт гэдэг нь нягтлан бодох бүртгэлийн дэвтэр, түүнийг орлох баримт, мөн нотолгоо баримтыг хэлэх ба дор дурдсан зүйлээс эдгээр тайлбар баримт ямар чухал болох нь харагдаж байна.

1. Аливаа хууль тогтоомжинд тодорхой заагдаагүй болон хязгаарлагдмал ухагдахуун байдаг.

2. Аливаа арилжаа гүйлгээ нь нарийн ээдрээтэй, олон төрөлтэй байдаг
3. Зөвхөн нотолгоо баримтаар аливаа гүйлгээ арилжааны талаар бүрэн гүйцэд ойлгож мэдэхэд хүндрэлтэй байх явдал цөөнгүй байдаг.
4. Аливаа арилжаа гүйлгээний нотолгоо баримтыг олж авч чадахгүй байх зайлшгүй шалтгаан гардаг.
5. Аж ахуйн нэгжийн дотоод арилжааны тухайд уг арилжааг хийх болсон хэрэгцээ шаардлага буюу арилжаа үнэн зөв хийгдсэн эсэх, тайланд зөв тусгагдсан эсэхийг тодорхойлох баримт хэрэгтэй байдаг.
6. Татварын бүртгэл хөтлөх стандарт боловсруулж байнга хэрэглэж хэвшүүлэн аливаа арилжаа гүйлгээг магадлан тогтооход хэмжүүр болгон ашиглах баримт хэрэгтэй байдаг.
7. Аливаа арилжаа гүйлгээ хийгдсэн бол үүнийг нотлох баримт олж авах боломжтой байдаг. Харин уг арилжааны өмнөх явцын талаарх нотолгоо баримт байвал тухайн арилжаа хийх болсон шалтгааныг тогтоож болно.
8. Бүртгэлд тусгах шаардлагагүй аливаа үйл ажиллагааны талаарх нотлох баримт ч гэсэн татварын тооцоонд хэрэгтэй байдаг.
9. Татварын хяналт шалгалт нь аливаа арилжаа гүйлгээ хийгдсэний дараа явагддаг тул «тухайн үе»-ийнх нь тайлбар баримт хэрэгтэй байдаг.
10. Байгууллагын санхүүгийн дотоод хяналт хийгдсэн баримтыг шууд тайлбар баримт болгодог.

Иймд татвар төлөгчийн хувьд ч гэсэн компанийн удирдлага, менежмент болон хувийн өмч хөрөнгийн хяналттай холбоотой үйл ажиллагааг нотолгоожуулах, холбогдох шалтгааныг тайлбарлах, татварын зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл болохын хувьд энэхүү баримтыг цэгцэлж бэлтгэх нь ихээхэн ач холбогдолтой байдаг. Мөн тайлбар баримтыг бэлдээд зогсохгүй түүнийг үр дүнтэй ашиглахад анхаарах хэрэгтэй.

Ингэснээр аливаа тайлбар баримт тухайн байгууллагын дотоод бичиг баримтаас нотолгоо болж чадах баталгаатай тоо, баримт болж хүчин төгөлдөр болдог. Татварын хяналт шалгалтаар нотолгоо баримтаар тогтоох боломжгүй аливаа эргэлзээтэй асуудлыг тодруулахад ач холбогдолтой тайлбар баримт нь татварын албанд аливаа шийдвэрийг «нотлох боломжтой» гэсэн «итгэл үнэмшил» төрүүлдэг тул татварын хяналт шалгалт эрчимтэй явагдаж татварын тайланг батлах магадлал өндөрсдөг. Ийм учраас эдгээр баримтыг бүрдүүлэхэд хүчин чармайлт тавих хэрэгтэй.